



ГАЗРЫН ХАРИЛЦАА, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН 2013 ОНЫ УЛСЫН НЭГДСЭН ТАЙЛАН

АГУУЛГА

ОРШИЛ

3

1. ТАЙЛАНТ ОНД ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ТАЛААР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ

1.1.	Газрын нэгдмэл сангийн удирдлага, менежмент	6-8
1.2.	Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаар хийсэн хяналт, шалгалт	9-13
1.3.	Өргөдөл, хүсэлт, тэдгээрийн барагдуулалтын судалгаа	13-14
1.4.	Газрын маргаан, түүнийг шийдвэрлэсэн байдал	14-16
1.5.	Газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын талаарх мэдээ, тайлан	17-19
1.6.	Газрын зах зээлийн тойм	19-22
1.7.	СӨХ-нд орчны газрыг ашиглуулах ажлын явц	23-24
1.8.	Газрын кадастрын судалгаа, хэмжил, зураглал гүйцэтгэсэн талаар	24
1.9.	Газар зохион байгуулалтын 2013 оны төлөвлөгөөний хэрэгжилт	24-25

2. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ТАЙЛАН

2.1.	Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал, газар ашиглалтын төрөлд гарсан өөрчлөлт, шилжилтийн үндэслэл /Маягт ГТ-1, 5/ Улсын тусгай хэрэгцээний газар /МАЯГТ ГТ-4/	28-36 36-37
2.2.	Газрын нэгдмэл сангийн эрх зүйн байдлын тайлан /Маягт ГТ-2/	38-40
2.3.	Газрын улсын бүртгэлийн тайлан /Маягт ГТ-3/	41-43
2.4.	Газарт учруулсан хохирлын тайлан /Маягт ГТ-6/	44-49
2.5.	Газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний тайлан /Маягт ГТ-7/	49-51
2.6.	Газрын төлбөр ногдуулалт, төлөлт /Маягт ГТ-8/	52-58
2.7.	Газар өмчлөлийн тайлан /Маягт ГТ-9/ ДҮГНЭЛТ, САНАЛ	58-60 61-62
	Хавсралт /тайлангийн ГТ1-9 маягт/	63-94

ГАЗРЫН ХАРИЛЦАА, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН 2013 ОНЫ УЛСЫН НЭГДСЭН ТАЙЛАН

Хянан тохиолдуулсан: Р.Ганхуяг ГХГЗЗГ-ын Газрын удирдлагын албаны дарга

Хэвлэлийн эх бэлтгэсэн: П.Нямдаваа ГХГЗЗГ-ын Кадастрын хэлтсийн мэргэжилтэн

Мөнхийн үсэг ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв

Улаанбаатар хот 2014 он

ОРШИЛ

Газрын нэгдмэл сангийн ангилал бүрийн газрын тоо бүртгэл, газрын улсын бүртгэл, шилжилт хөдөлгөөн, газарт учирсан хохирол, газар хамгаалах талаар авсан арга хэмжээ, газрын төлбөр ногдуулалт, төвлөрүүлэлт зэрэг үзүүлэлтийг засаг захиргааны нэгж тус бүрээр тусган улсын газрын нэгдмэл сангийн тайланг гаргаж, Засгийн газарт танилцуулж байхаар “Газрын тухай” Монгол улсын хуулийн 26 дугаар зүйлийн 2.6-д заасан билээ. Уг заалтын дагуу аймаг, нийслэлийн 2013 оны газрын нэгдмэл сангийн тайланг Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын нэгдмэл сангийн тайлан гаргах журам” болон Засгийн газрын 2003 оны 204 дүгээр тогтоолоор батлагдсан тайлангийн ГТ1-9 маягтын дагуу нэгтгэн танилцуулж байна.

Газрын нэгдмэл сангийн улсын тайлан нь тайлангийн хугацаанд газрын ангилал болон газар өмчлөл, эзэмшил, ашиглалтын эрх зүйн байдал, тэдгээрт гарсан өөрчлөлтөд дүгнэлт өгөх, газрын талаар авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг тодорхойлох, цаашид газрыг өмчлөх, эзэмших, ашиглах, хуваарилах, хамгаалах, нөхөн сэргээх болон газар зохион байгуулалтын бусад арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, газрын нэгдмэл сангийн өгөгдөхүүнд өөрчлөлт оруулах, улс, орон нутгийн статистик мэдээнд ашиглахад суурь материал болдог ач холбогдолтой.







1

**ТАЙЛАНТ ОНД ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ
ТАЛААР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ**

1.1. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН УДИРДЛАГА, МЕНЕЖМЕНТ

Газрын салбарт Барилга, хот байгуулалтын яаманд 5, Газрын харилцаа, геодези зураг зүйн газарт 73, нийслэл, дүүргийн Өмч, газрын харилцааны албанд 300, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт 361, суманд Газрын даамал 352, нийт 1091 албан хаагч ажиллаж байна.

Хаягжуулалтын тухай хуулийг 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаар батлуулав.

Газрын тухай, Газрын төлбөрийн тухай, Газрын кадастрын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төсөл, Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулж 2013 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, 2013 оны 01 дүгээр сарын 11-нд Улсын Их Хуралд өргөн барьсан. Эдгээр хуулиудын төслийг УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг дээр хэлэлцүүлж байна.

“Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”-ыг Засгийн газрын 2013 оны 280 дугаар тогтоолоор батлуулав.

Монгол Улсын Засгийн газраас жил бүрийн 05 дугаар сарын эхний долоо хоногийн ням гарагийг “Газрын харилцааны ажилтны өдөр” болгосонтой холбогдуулан уг өдрийг өндөр түвшинд амжилттай тэмдэглэн өнгөрүүлсэн.

“Газрын харилцааны ажилтны өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотойгоор байгууллагын вэб сайтаас гадна Өдрийн сонин, Зууны мэдээ сонин болон өдөр тутмын телевиз радиогоор мэдээлэл хийж, Монгол Улсын газрын салбарын бодлого, үйл ажиллагааг иргэд, олон нийтэд улс даяар өргөн хүрээгээр сурталчлав.

Улсын хэмжээнд хэрэглэгддэг www.zasag.mn, www.gazar.gov.mn сайт болон байгууллагын facebook, twitter хуудсаар дамжуулан Монгол улсын газрын салбарын хууль тогтоомж, бодлого, хэрэгжилт, төсөл арга хэмжээ зэрэг хэрэгцээт мэдээллийг харьяа байгууллага, иргэд, олон нийтэд тухай бүр мэдээлж байна.

“Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн суурь мэдээллийг бий болгох”, “Хаягийн мэдээллийн


систем байгуулах”, “Газрын кадастрын мэдээллийн сан”-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлуудыг эхлүүлэв.



Дорнод, Дорноговь, Өмнөговь, Баян-Өлгий, Ховд, Сэлэнгэ аймгуудад GPS-ын байнгын ажиллагаатай станц суурилуулав.

Сумдын газрын даамлуудыг орон тооны, мэргэжлийн ажилтнуудтай болгох асуудлыг анхааран ажилласны үр дүнд 62% нь мэргэжлийн орон тооны ажилтан болсон байна /Зураг 1.1.1/.



Зураг 1.1.1: Сумдын газрын даамлуудын мэргэшсэн байдал






Зураг 1.1.2: Сумдын газрын даамлуудын насны ангилал болон хүйсийн харьцаа

1.1.3: Сумдын газрын даамлууд Төрийн албанд мэргэшсэн байдлыг жилээр нь авч үзвэл:


1.1.1: Сумдын газрын даамлуудын тоо 2013 оны жилийн эцсийн байдлаар

№	Аймгийн нэр	Нийт сумдын тоо	2 даамалтай сумдын тоо	Мэргэжлийн боловсон хүчин	Бусад мэргэжлийн	Бүгд
1	Архангай	19	1	10	10	20
2	Баян-Өлгий	13	1	10	4	14
3	Баянхонгор	20	1	11	10	21
4	Булган	16	1	11	6	17
5	Говь-Алтай	18		7	11	18
6	Говьсүмбэр	3		3	-	3
7	Дархан-Уул	4		3	-	3
8	Дорнод	14		10	4	14
9	Дорноговь	14	2	10	6	16
10	Дундговь	15		7	8	15
11	Завхан	24		11	14	25
12	Орхон	2		2		2
13	Өвөрхангай	19	2	20	1	21
14	Өмнөговь	15	1	12	4	16
15	Сэлэнгэ	17	2	15	4	19
16	Сүхбаатар	13		10	3	13
17	Төв	27	1	23	5	28
18	Увс	19	2	16	5	21
19	Ховд	17	1	18	-	18
20	Хэнтий	17	1	11	12	23
21	Хөвсгөл	23	1	17	8	25
	Нийт	330	17	237	115	352


Аймгуудын Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт ажлын байрны тодорхойлолтын дагуу 361 албан хаагчид үүрэгт ажлаа гүйцэтгэж байна /Зураг 1.1.4/.




Зураг 1.1.4: Салбарын албан хаагчидын бүтэц



Зураг 1.1.5: Аймгуудын ГХБХБГ-ын ажилчдын насны ангилал



Зураг 1.1.6: Аймгуудын ГХБХБГ-ын ажилчдын хүйсийн харьцаа



Зураг 1.1.7: Аймгуудын ГХБХБГ-ын ажилчдыг Төрийн албанд мэргэшсэн байдал /жилээр/

1.2. ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ


2013 онд улсын хэмжээнд Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд хийсэн 1020 удаагийн хяналт, шалгалтаар нийт 11909 зөрчил илэрчээ/Хүснэгт 1.2.1/.

Хүснэгт 1.2.1: Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд хийсэн хяналт шалгалт /аймаг, нийслэл/ -ын тоо, төрлүүд

№	Аймгийн нэр	Явуулсан хяналт шалгалтын тоо	Нийт илэрсэн зөрчил	Үүнээс									
				Газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биеллэгүй	2 жил дараалан ашиглаагүй	Гэрээнд заасан зориулалт бусаар газар ашигласан	Үүнээс			Газрын хэмжээг өөрчлөн хашаагаа сунгасан	Эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй газар ашигласан	Тухайн жилийн ГЗБТ-нд тусгагдаагүй газарт газар олгосон	Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас хамаарсан
							Газар эзэмших, ашиглах эрхийн хугацаа дууссан	Газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй	Газрын хэмжээг өөрчлөн хашаагаа сунгасан				
1	Архангай	50	117	92	48	0	1	10	33	20	5	0	
2	Баян-Өлгий	100	186	79	34	11	3	27	4	83	18	6	
3	Баянхонгор	60	219	198	98	11	21	58	10	21	0	0	
4	Булган	35	734	665	264	5	8	388	0	65	0	4	
5	Говь-Алтай	63	223	182	27	8	28	119	0	20	0	21	
6	Говьсүмбэр	3	37	32	0	0	0	32	0	0	5	0	
7	Дархан-Уул	15	507	484	112	10	107	238	17	7	16	0	
8	Дорнод	25	158	146	15	0	1	120	10	11	0	1	
9	Дорноговь	6	58	17	5	2	0	10	0	38	0	3	
10	Дундговь	20	256	247	3	1	0	227	16	8	1	0	
11	Завхан	11	92	49	9	1	0	39	0	43	0	0	
12	Орхон	2	519	491	486	1	0	0	4	27	0	1	
13	Өвөрхангай	45	222	212	149	2	0	0	61	10	0	0	
14	Өмнөговь	21	2096	2076	84	3	41	1923	25	20	0	0	
15	Сэлэнгэ	50	408	341	63	8	8	262	0	66	0	1	
16	Сүхбаатар	6	39	29	12	5	0	0	12	10	0	0	
17	Төв	159	895	847	545	35	103	164	0	48	0	0	
18	Увс	63	219	145	39	4	15	14	73	52	15	7	
19	Ховд	62	297	196	63	0	5	111	17	78	21	2	
20	Хэнтий	44	165	104	53	3	0	18	30	29	0	32	
21	Хөвсгөл	90	779	679	86	23	553	17	0	100	0	0	
22	Улаанбаатар	90	3683	3288	2136	14	818	320	0	392	0	3	
Дүн		1020	11909	10599	4331	147	1712	4097	312	1148	81	81	


Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд хийсэн хяналт, шалгалт тоо, хэмжээ улсын хэмжээнд 2010-2012 онуудад жил дараалан буурсан үзүүлэлттэй байсан бол 2013 онд 1020 буюу өнгөрсөн оны хяналт шалгалтын тоотой харьцуулбал 6,5%-иар өссөн байна.

2010-2013 онуудад Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд хийсэн хяналт, шалгалтын тоог графикаар харуулбал:




Зураг 1.2.1: Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд хийсэн хяналт, шалгалт хийгдсэн тооны харьцуулалт

2013 онд хяналт шалгалтыг Улаанбаатар хот, Төв, Баян-Өлгий, Хөвсгөл, Говь-Алтай, Увс, Ховд, Баянхонгор аймгууд хамгийн олон буюу 60-159 удаа явуулсан байна /Зураг 1.2.2/.



Зураг 1.2.2: Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэндхийсэн хяналт, шалгалт хийгдсэн тоо


Архангай, Говь-Алтай, Говь-Сүмбэр, Дархан, Дорнод, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Увс, Төв аймгууд хяналт шалгалтыг олон удаа хийж, сумуудаа бүрэн хамруулж сайн ажилласан бол Сүхбаатар, Дорноговь, Завхан аймгууд хангалтгүй явуулсан байна.



Зураг 1.2.3: Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд хийсэн хяналт, шалгалтанд сумдыг хамруулсан хувь

Газрын тухай хууль, тогтоомжийн биелэлтэнд хийсэн хяналт, шалгалтын тоо, нийслэлийн хэмжээнд жил дараалан буурч 2012 оны хяналт шалгалтын тоо 2011 онд хийсэн хяналт шалгалтын тооноос 75%-иар буурсан бол 2013 онд хийгдсэн хяналт шалгалтын тоо өнгөрсөн оны хяналт шалгалтын тоотой харьцуулбал 2.8 дахин өссөн байна.

Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн тоо улсын хэмжээнд 2010-2012 онуудад жил дараалан буурсан үзүүлэлттэй байсан бол 2013 онд 11909 болж 2012 онд илэрсэн зөрчлийн тоотой харьцуулвал 85,6%-иар өссөн байна /Зураг 1.2.4/.



Зураг 1.2.4: 2010-2013 онд Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд хийсэн хяналт, шалгалт хийгдсэн тоо болон илэрсэн зөрчил

2013 онд Газрын хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд хийсэн хяналт, шалгалтаар илэрсэн 11909 зөрчлийн 10599 буюу 89% нь газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, 1148 буюу 9.6% нь эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй газар ашигласан зөрчил эзэлж

байгаа бол 81 буюу 0.7% нь тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт газар олгосон зөрчил, мөн тооны хувийг төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас хамаарсан зөрчил тус тус эзэлж байна.



Зураг 1.2.5: Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд хийсэн хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийн төрөл, түүний харьцуулалт

2010-2013 онуудад Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүдээс газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зөрчил нийт зөрчлийн 75-89%, эрх бүхий албан тушаалтны


зөвшөөрөлгүй газар ашигласан зөрчил 9.6-24.4%-ийг эзлэж байгаа бол төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас хамаарсан зөрчил 0,3-3%-ийг тус тус эзлэж байна.

Хүснэгт 1.2.2: Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн төрөл, тоо хэмжээ, түүний харьцуулалт

№	Зөрчил	2010 он	2011 он	2012 он	2013 он
1	Газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зөрчил	7614	7351	4868	10599
		Өмнөх оныхоос 4% -иар буурсан	Өмнөх оныхоос 3,5% -иар буурсан	Өмнөх оныхоос 33,8% -иар буурсан	Өмнөх оныхоос 117,7% -иар өссөн
2	Эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй газар ашигласан зөрчил	2471	1209	1515	1148
		Өмнөх оныхоос 5%-иар өссөн	Өмнөх оныхоос 51,1%-иар буурсан	Өмнөх оныхоос 25% -иар өссөн	Өмнөх оныхоос 24,2% -иар буурсан
3	Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас хамаарсан зөрчил	32	265	31	81
		0%	Өмнөх оныхоос 728%-иар өссөн	Өмнөх оныхоос 88,3 -иар % буурсан	Өмнөх оныхоос 161,3-иар % өссөн

2013 онд хяналт шалгалтын тоо өссөнтэй холбогдуулан газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас хамаарсан зөрчил өмнөх оныхоос өссөн үзүүлэлттэй байна. Газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зөрчлийг дотор нь ангилж авч үзвэл 2 жил дараалан ашиглаагүй зөрчил 4331 /40.9%/,

гэрээнд заасан зориулалт бусаар газар ашигласан зөрчил 147 /1.4%/ , газар эзэмших, ашиглах эрхийн хугацаа дууссан зөрчил 1712 /16.2%/ , газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй зөрчил 4097 /38.7%/ , газрын хэмжээг өөрчлөн хашаагаа сунгасан 312 /2.9%/ зөрчил тус тус эзэлж байна. Газар эзэмших, ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зөрчлийг өмнөх онуудтай ангиллаар харьцуулж харуулбал:



Зураг 1.2.6: Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зөрчлийн ангилал, төрөл, түүний харьцуулалт


Дээрх харьцуулалтаас харахад гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зөрчлийн 2 жил дараалан ашиглаагүй зөрчил 24-40%, гэрээнд заасан зориулалт бусаар газар ашигласан зөрчил 1.4-5.6%, газар эзэмших, ашиглах эрхийн хугацаа дууссан зөрчил 6.1-22.2%, газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй зөрчил дийлэнх хувийг буюу 38-63%-ийг тус тус эзэлж байна. Харьцуулалтаас харвал гэрээнд заасан зориулалт бусаар газар ашигласан зөрчил өмнөх оныхоос 47%-иар буурсан бол 2 жил дараалан ашиглаагүй, газар эзэмших, ашиглах эрхийн хугацаа дууссан, газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй зөрчлүүд өмнөх жилүүдэд буурч байсан бол 2013 онд дээрх зөрчлүүдийн тоо тус бүр 2 дахин өссөн байна.

Газрын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт шалгалтыг мэргэжлийн хяналтын байгууллага

болон цагдаагийн байгууллагатай хамтран хяналт шалгалтыг хийхээс гадна Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын зүгээс газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, аймаг болон сумын мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажилласан.

1.3. ӨРГӨДӨЛ, ХҮСЭЛТ, ТЭДГЭЭРИЙН БАРАГДУУЛАЛТЫН СУДАЛГАА

Иргэн, хуулийн этгээдийн ирүүлсэн өргөдөл хүсэлтийн судалгааг 2013 оны байдлаар улсын хэмжээнд нэгтгэн дүгнэхэд нийт 87439 /100%/ өргөдөл, хүсэлт ирүүлснээс шинээр газар эзэмших 33097 /38%/ болон шинээр газар өмчлөх 30381 /35%/ өргөдөл хүсэлт ихэнх хувийг эзэлж байна / Зураг 1.3.1/.



Зураг 1.3.1: Өргөдөл, хүсэлт тэдгээрийг барагдуулсан байдал


Улсын хэмжээнд нийт 87439 өргөдөл хүсэлт ирснээс 74951 /86%/ өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэсэн бол 12488 /14%/ өргөдөл хүсэлт шийдвэрлэгдээгүй байна.

Өргөдөл, хүсэлтийг шийдвэрлээгүй нийтлэг шалтгаан нь тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт хүсэлт гаргасан, дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт явагдсанаас хойш материалаа ирүүлсэн, бичиг баримтын зөрчилтэй, баримт бичгийн бүрдүүлэлт дутуу, инженерийн шугам сүлжээ бүхий газар, авто замын зурвас газарт орсон, нисэхийн хориотой бүсэд, үерийн аман дээр газар ашиглах, эзэмших, өмчлөх, зөвшөөрөлгүй газар дээр газар ашиглах, тусгай хамгаалалттай газарт орсон зэрэг хүсэлт гаргаснаас болж шийдвэрлэх боломжгүй байна.

Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй түүнчлэн шинээр эзэмшүүлэх болон өмчлүүлэх газрын нөөц бага, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлээгүй зэргээс шалтгаалж өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй байна.

1.4. ГАЗРЫН МАРГААН, ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

Газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхтэй холбогдон гарсан маргааны судалгааг 2013 оны байдлаар улсын хэмжээнд нэгтгэн дүгнэхэд нийт 2034 маргаан гарснаас ихэнх хувийг газар эзэмшихтэй холбоотой 1177 /58%/ болон газар өмчлөхтэй холбоотой 690 /34%/маргаан эзэлж байна. Нийт гарсан маргаанаас 1692 газрын маргааныг шийдвэрлэж хариу өгөөд байна /Зураг 1.4.1/.



Зураг 1.4.1: Газрын маргааныг шийдвэрлэсэн байдал

Гарч буй зөрчил, маргааны шалтгаан нь дараах хэлбэрүүдээр гарч байна:

- Зөвшөөрөлгүй хашаагаа сунгах,
- Нийтийн эзэмшлийн талбайг зөвшөөрөлгүй ашиглах,
- 1 давхрын өргөтгөл хийх,
- Газар эзэмшүүлэх гэрээний нөхцлөө зөрчсөн,
- Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй,
- Хашааг эзэмшил газрын хэмжээнээс хэтрүүлэн барьсан,

- Газрын төлбөрөө хугацаандаа төлөөгүй,
- Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулаагүй
- Газрыг давхардуулан эзэмшүүлэх.

Шийдвэрлэгдээгүй 342 маргаан үлдсэн бөгөөд гол шалтгаан нь үл хөдлөх хөрөнгийн холбогдолтой тул шүүхийн шийдвэрийг хүлээх, мэргэжлийн хяналтын байгууллагаар шалгуулах, мөн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн маргааныг Засгийн газраас томилогдсон холбогдох байгууллагуудын хамтарсан ажлын хэсгийн дүгнэлтийг хүлээх зэрэгтэй холбоотой байна.

Хүснэгт 1.4.1: Газрын маргаан, түүнийг шийдвэрлэсэн байдал /аймаг, нийслэлээр/

	Аймгийн нэр	Маргааны тоо				Үүнээс							
		Эзэмших	Өмчлөх	Хилийн цэсийн	Ашиглах	Шийдвэрлэгдсэн				Шийдвэрлэгдээгүй			
						Эзэмших	Өмчлөх	Хилийн цэсийн	Ашиглах	Эзэмших	Өмчлөх	Хилийн цэсийн	Ашиглах
1	Архангай	30	47	2	0	24	38	1		6	9	1	
2	Баянхонгор	74	38	19	0	68	38	9	0	6	0	10	0
3	Баян-Өлгий	190	48	3	54	175	43	3	50	15	5	0	4
4	Булган	148	11	4	0	99	11	3	0	49	0	1	0
5	Говь Алтай	36	3	9	3	34	2	8	2	2	1	1	1
6	Говьсүмбэр	8	1	0	0	3	1	0	0	5	0	0	0
7	Дархан-Уул	12	3	0	0	3	3	0	0	9	0	0	0
8	Дорнод	8	28	1	0	7	20	1	0	1	8	0	0
9	Дорноговь	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
10	Дундговь	15	4	6	0	13	2	6	0	2	2	0	0
11	Завхан	145	3	8		77	3	6		68		2	
12	Орхон	118	350	0	0	118	350	0	0	0	0	0	0
13	Өвөрхангай	5	1	5		4	1	5		1			
14	Өмнөговь	11	0	0	0	11	0	0	0	0	0	0	0
15	Сүхбаатар	1	45	0	0	0	34	0	0	1	11	0	0
16	Сэлэнгэ	33	8	2	4	32	6	2	4	1	2	0	0
17	Төв	64	22	22	0	51	20	16	0	13	2	6	0
18	Увс	58	17	4	0	37	15	4	0	21	2	0	0
19	Ховд	77	28	5	0	61	18	5	0	16	10	0	0
20	Хөвсгөл	116	2	8	0	102	1	7	0	14	1	1	0
21	Хэнтий	28	31	8	0	16	18	1	0	12	13	7	0
22	Улаанбаатар												
	Дүн	1177	690	106	61	935	624	77	56	242	66	29	5

2013 онд ГХГЗЗГ-т бүх шатны шүүхээс болон иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөлд хариу өгсөн байдлыг дүгнэхэд шинжээчийн дүгнэлт 58, тайлбар нотолгоо 116-ийг гаргаж өгсөн байна. Тус газарт бүх шатны шүүхээс болон иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөлийн тоог урд оны тоотой харьцуулахад 2 дахин өссөн байна.

Цаашид газрын зөрчлийг гарсан хойно нь шийдвэрлэх, арилгах тал дээр ихээхэн хөрөнгө мөнгө, хугацаа зарцуулахын оронд маргаан

зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, бууруулах талаар тодорхой судалгаа, дүн шинжилгээ хийх гарч буй шалтгаанаар нь ангилж бүртгэн, гарах үр дагаврыг тооцон урьдчилан сэргийлж газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах, мөрдүүлэх нээлттэй ил тод болгох, мөн зөрчил, маргааныг иргэдэд чирэгдэл багатай доод шатандаа шийдвэрлэдэг болох, ингэснээр шүүхээр дамжуулан шийдвэрлэдэг маргааны тоог бууруулах боломжтой юм.

1.5. ГАЗРЫН ДУУДЛАГА ХУДАЛДАА, ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭ, ТАЙЛАН

Газрын тухай хуулийн 33.1.2, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5.1.6.2, мөн хуулийн 5.1.8.2-т заасны дагуу газрыг дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын зарчмаар олгож байна.

Сүүлийн жилүүдэд газартай холбоотой зөрчил, маргаан ихсэж байгаатай холбоотойгоор газар эзэмших, ашиглах эрхийг иргэд, олон нийтэд илүү нээлттэй, тэгш шудрага зарчмаар олгох үүднээс дуудлага худалдааны зарчмыг баримтлах хандлага ажиглагдаж байна.

Газар зохион байгуулалтын тухайн жилийн

төлөвлөгөөнд тусгаж, тухайн шатны ИТХ-аас баталсан байршил дээр аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын томилсон комисс Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын дагуу зохион байгуулдаг.

Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн дуудлага худалдааны анхны үнийг Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоол болон ЗТБХБ /хуучин нэрээр/-ын Сайдын 2010 оны 206 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлал”-ын дагуу тодорхойлж байна.

2013 онд улсын хэмжээнд дуудлага худалдааны зарчмаар нийт 6628.53 га талбайг эзэмшүүлсэн байна.


Хүснэгт 1.5.1: 2013 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа зохион байгуулсан байдал

№	Аймаг	Дуудлага худалдаа явуулсан тоо	Дуудлага худалдааны төрөл			Талбай /га/	Төсөвт орсон орлого /мян.төг/
			Өмчлөх	Эзэмших	Ашиглах		
1	Архангай	51		51		13.16	58,008.9
2	Баян-Өлгий	3		3		0.3	77,750.0
3	Баянхонгор	10		10		2.4	14,989.4
4	Булган	24		24		821.3	126,342.0
5	Говь-Алтай	0		0		0	0
6	Говьсүмбэр	7		7		19.0	13,201.7
7	Дархан-Уул	5		5		0.32	135,100.0
8	Дорнод	60		60		122.5	85,205.1
9	Дорноговь	60		60		113.9	1,465,845.4
10	Дундговь	0		0		0	0
11	Завхан	0		0		0	0
12	Орхон	2		2		0.4	220,440.0
13	Өвөрхангай	9		9		30.4	15,655.6
14	Өмнөговь	17		17		25.0	29,740.0
15	Сүхбаатар	7		7		5,000.4	751,050.0
16	Сэлэнгэ	33		33		12.9	44,079.9
17	Төв	20		20		118.9	135,862.0
18	Увс	21		21		3.8	48,827.7
19	Ховд	18		18		1.0	5,368.0
20	Хөвсгөл	24		24		249.4	149,514.5
21	Хэнтий	57		57		122.6	85,205.1
22	Улаанбаатар	0		0		0	24,453,616.1
	Дүн	428		428		6628.4	27,915,801.4

2013 онд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаагаар улсын хэмжээнд нийт 27.9 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт оруулсны дотор Нийслэлээс 88.4 %-ийг төвлөрүүлсэн байна.

Үүний 24.4 тэрбум төгрөгийг Нийслэлийн Засаг даргын 2013 оны 307, 309, 915 дугаар захирамжийн дагуу газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн дуудлага худалдааны анхны үнийг мэдэгдэл, нэхэмжлэлээр нөхөн ногдуулж авсан байна.

2013 онд Газрын тухай хуульд заасан дуудлага худалдааны журмаар 421 иргэн, аж ахуйн нэгж газар эзэмших эрхтэй болсон байна. Үүний үр дүнд 27 тэрбум 915.8 сая төгрөгний орлого улсын төсөвт төвлөрсөн байна/Зураг 1.5.1/.



Зураг 1.5.1: 2012-2013 онд газар эзэмшүүлэх дуудлага худалдаагаар улсын төсөвт орсон орлого /сая.төг/

2012 онд газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн дуудлага худалдааны орлогоос орон нутгийн төсөвт 5.5 тэрбум төгрөг орсон бол 2013 онд 4.8 дахин өссөн байна.

Энэ нь дээр дурьдсан Нийслэлийн Засаг даргын 2013 оны 307, 309, 915-р захирамжийн дагуу газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн дуудлага худалдааны анхны үнийг мэдэгдэл, нэхэмжлэлээр нөхөн ногдуулж авсантай холбоотой байна.

Шинэ бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүд нэмэгдэх, уул уурхайн хөгжилтэй холбоотойгоор газар эзэмших, ашиглах, өмчлөх эрэлт нэмэгдэж байгаа нь цаашид газрыг дуудлага худалдааны зарчмаар олгох шаардлага нэмэгдэхийг

харуулж байна.

Харин нийгэм-эдийн засгийн хөгжлийн төлөв тодорхойгүй буюу хүн амын суурьшил бага, дэд бүтэц муу сумдад газрын эрэлт хэрэгцээ бага учраас дуудлага худалдаагаар газар эзэмших сонирхолгүй байна.

Тайлангийн хугацаанд улсын хэмжээнд 384.6 га газарт 56 удаа төсөл сонгон шалгаруулалт явуулж ХАА-н үйлдвэрлэл, амралт сувилал, шатахуун түгээх станц, худалдаа үйлчилгээ эрхлэх, орон сууц барих зориулалтаар эзэмшүүлсэн байна.

Хүснэгт 1.5.2: 2013 оны төсөл сонгон шалгаруулалтын мэдээ

№	Аймаг	Төсөл сонгон шалгаруулалт явуулсан тоо	Талбай /га/
1	Булган	10	7.2
2	Говь-Алтай	12	25.2
3	Дорнод	13	138
4	Орхон	5	2.3
5	Өвөрхангай	11	3.1
6	Өмнөговь	2	199.5
7	Ховд	3	9.42
Нийт дүн		56	384.6

Улсын хэмжээнд Дорнод аймаг хамгийн олон төсөл сонгон шалгаруулж газар эзэмшүүлсэн бол Говь-Алтай, Өвөрхангай, Булган аймаг удаалж байна.

Өнгөрсөн онд Нийслэл, Завхан, Дундговь, Говь-Алтай аймгийн Засаг даргын захирамж, шийдвэрээр газар эзэмшүүлэхийг түр хугацаагаар зогсоосонтой холбоотойгоор газрын эрхийн дуудлага худалдаа зохион байгуулаагүй байна

Аймгуудаас ирүүлсэн тайлангаас үзэхэд орон нутагт дуудлага худалдааг хууль, журмын дагуу ил тод зохион байгуулж байна. Харин дуудлага худалдаагаар газар эзэмшүүлэх, ашиглуулах журам өнөөгийн харилцааг бүрэн зохицуулж чадахгүй байгаа нь харагдаж байна.

2014 онд ихэнхдээ аймгийн төвийн сумдад

инженерийн шугам сүлжээнд ойр, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан орон нутгийн хөгжилд ач холбогдол бүхий газруудыг сонгож, илүү нээлттэй, ил тод зарчимаар олгохоор төлөвлөжээ.

1.6. ГАЗРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Газрын зах зээл нь маш олон хүчин зүйлсээс хамааралтай байна. Газар зүйн онцлог, дэд бүтэц, газар ашиглалт, хүн амын нягтрал, суурьшил, нээлттэй ил тод байдал болон эдийн засгийн потенциал зэрэг олон хүчин зүйл нь газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлд нөлөөлж, үнэ тогтоох үндэс болж байна.

Улсын хэмжээнд 2013 оны байдлаар 433293 үл хөдлөх эд хөрөнгө, 692220 газарөмчлөгч, эзэмшигч, ашиглагч бүртгэгджээ. Үүнээс 2013 онд газрын зах зээлийн харилцаанд орсон байдлыг дараах үзүүлэлтүүдээр харж болох юм. Үүнд:

- Нийт газарөмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн 54035 нь буюу 7.8 хувь нь эрхийн харилцаанд оржээ.
2012 он: 6637эрх шилжсэн(1687 эзэмших+8294 өмчлөх)
2013 он: 17824 эрх шилжсэн (11034 эзэмших+6790 өмчлөх)
4744 бэлэглэсэн (өмчлөх)
31467 эрхээ барьцаалсан (8652 эзэмших+22815 өмчлөх)
- Газар эзэмших, өмчлөх эрхийн санхүүгийн эргэлтийн хэмжээ 2 дахин нэмэгджээ.
2012 он: 357 тэрбум 808 сая төгрөг
2013 он:689 тэрбум төгрөг
- 2013 оны байдлаар нийт газар нутгийн ойролцоогоор 0.001 хувь нь эрхийн өөрчлөлтөд оржээ.
2012 он: 1553 га газар эдийн засгийн эргэлтэнд орсон байна
2013 он: 15803 га газар эдийн засгийн эргэлтэнд

орсон байна

Монгол улсын ДНБ 21.3 их наяд төгрөг ба үл хөдлөх эд хөрөнгийн санхүүгийн эргэлтийн хэмжээ 2,522.8 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 11.07%байна.

Харин газрын зах зээлийн санхүүгийн эргэлтийн хэмжээ ДНБ-ний 3.02% эзэлж байна.


Үүнээс үзэхэд Монгол улсын нийт үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд бүртгэж, газрыг нягтлан бодох бүртгэлд бүртгэж, газрын зах зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг иргэд, олон нийтийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бий болговол ДНБ-ийг 2 %-иар өсгөх, ДНБ-ий 15 %-ийг бүрдүүлэх нөөц боломж байгаа нь харагдаж байна.

2013 онд улсын хэмжээнд 21 аймгийн ГХБХБГ, НӨХГ-аас улирал бүрээр, “Монгол улсын хэмжээнд газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ цуглуулах, мэдээллийн сан байгуулах, дүн шинжилгээ хийх” зөвлөх үйлчилгээгээр гэр хороолол /ГХ/, хөдөө аж ахуй /ХАА/, худалдаа үйлчилгээ /ХҮ/, үйлдвэр /Ү/ гэсэн 4 төрлөөр нийт 5451 үнийн мэдээ цуглууллаа.

Үүнээс 21 аймгийн ГХБХБГ, НӨХГ-аас 2967 үнийн мэдээ, “Монгол улсын хэмжээнд газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ цуглуулах, мэдээллийн сан байгуулах, дүн шинжилгээ хийх” зөвлөх үйлчилгээгээр 2484 үнийн мэдээ ирүүлээд байна.

Гэр бүлийн зориулалттай газар

Улсын хэмжээнд гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын зах зээлийн үнийн 4609 мэдээ цуглуулаад байна.



Зураг 1.6.3: Гэр бүлийн хэрэгцээний м² газрын дундаж үнэ

Дээрх мэдээнээс үзэхэд улсын дунджаар 1 нэгж талбар 12 сая төгрөг, 1 метр квадрат газар 22 мянган төгрөгийн үнэтэй байна.


Гэр бүлийн зориулалттай нэг м² газрын дундаж үнэ Баян-Өлгий, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Сүхбаатар, Увс аймагт 30000-50000 төгрөг, Архангай, Баянхонгор, Булган, Дундговь,

Өвөрхангай, Өмнөговь, Төв, Хэнтий аймагт 10000-30000 төгрөг, Говь-Алтай, Говьсүмбэр, Завхан, Орхон, Сэлэнгэ, Ховд, Хөвсгөл аймагт 3000-10000 төгрөг тус тус байна.

Харин Улаанбаатар хотын хувьд 2012 онд гэр бүлийн хэрэгцээний газрын м² газрын дундаж үнэ 59000 төгрөг байсан бол 2013 онд 60803 төгрөг болсон байна.

Худалдаа үйлчилгээний зориулалттай газар

Улсын хэмжээнд ХҮ-ний зориулалттай газрын зах зээлийн үнийн 504 мэдээ цуглуулаад байна.



Зураг 1.6.4: Хөрөнгө оруулалт хийгдсэн худалдаа, үйлчилгээний зориулалттай газрын үнэ

Архангай, Өмнөговь, Увс, Хөвсгөл аймагт худалдаа үйлчилгээний зориулалттай м² газрын үнэ их буюу 300000-400000 төгрөг байна. Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай, Төв, Хэнтий аймагт худалдаа үйлчилгээний зориулалттай м² газрын үнэ дундаж буюу 1000000-300000 төгрөг байна. Харин Булган, Сэлэнгэ аймагт худалдаа үйлчилгээний зориулалттай м² газрын үнэ бага буюу 50000-100000 төгрөг байна.

ХАА-н зориулалттай газар

Улсын хэмжээнд худалдаа үйлчилгээний зориулалттай газрын зах зээлийн үнийн 250 мэдээ цуглуулаад байна. Энэ онд өмнөх жилүүдээс харьцангуй их үнийн мэдээ цуглуулсан ба үүнээс тариалангийн газрын зах зээлийн үнийн мэдээ дийлэнх хувийг эзэлж байна. Үүнээс үзэхэд манай улсад хөдөө аж ахуйн газрын зах зээл хөгжиж байгаа нь харагдаж байгаа юм.

Хэдийгээр ДНБ-д газрын зах зээлийн санхүүгийн эргэлтийн эзлэх хувь нэмэгдэж байгаа ч Монгол

улсад газар эзэмших, ашиглах эрхийг нягтлан бодох бүртгэлд өмч гэж үзэж бүртгэхгүй байсаар байна.


Иймд улсын хэмжээнд газрын суурь үнийг зах зээлийн нөхцөл байдалд нийцүүлэн шинэчлэн тогтоож, зах зээлийг нээлттэй уян хатан болгосноор газраас хүртэх эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Төрийн бодлогыг газрын зах зээлийн хөгжилтэй уялдуулах, олон улсын жишигт нийцсэн өөрийн орны онцлогт тохирсон газрын үнэлгээний тогтолцоог бий болгох, аймаг, сумдад газрын үнэлгэний үйлжиллагааг зах зээлийн жишигт нийцүүлэн эрхлэх шаардлагатай байна.

Үүний тулд эрхийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой харилцаанд оролцож буй байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар үнэн бодит зах зээлийн үнийн мэдээ цуглуулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, мэдээллийн санг байгуулж иргэд, олон нийтэд нээлттэй болгох ажлыг хийх шаардлагатай байна.

1.7. СӨХ-НД ОРЧНЫ ГАЗРЫГ АШИГЛУУЛАХ АЖЛЫН ЯВЦ

2013 оны байдлаар улсын хэмжээнд нийт 471 Сууц өмчлөгчдийн холбоо байгаагаас нийслэлд 384, орон нутагт 87 нь үйл ажиллагаа явуулж байна /Зураг 1.7.1/.



Зураг 1.7.1: Сууц өмчлөгчдийн холбоодын өөрчлөлт

Хүснэгт 1.7.1: СӨХ-ны орчны газрын баталгаажилтын явц /Улсын хэмжээнд/

д/д	Аймаг, сумын нэр	2012			2013		
		Нийт СӨХ-дын тоо /2012 он/	Орчны газрыг нь баталгаажуулсан СӨХ-ны тоо	Ашиглаж байгаа талбайн Хэмжээ /м²/	Нийт СӨХ-дын тоо /2013 он/	Орчны газрыг нь баталгаажуулсан СӨХ-ны тоо	Ашиглаж байгаа талбайн Хэмжээ /м²/
1	Архангай	1	1	47900	1	1	47900
2	Баянхонгор	3	1	47016	1	0	47016
3	Баян-Өлгий	-	-	-	-	-	-
4	Булган	1	1	32197.9	1	1	32197.93
5	Говь-Алтай	7	2	17406.3	5	5	51000
6	Говьсүмбэр	4	4	131535	-	-	-
7	Дархан-Уул	28	12	552113	22	22	508617
8	Дорнод	10	10	218531	9	9	215531
9	Дорноговь	10	10	147452	11	11	161156.8
10	Дундговь	1	1	15000	1	1	15700
11	Завхан	2	2	28285.8	-	-	-
12	Орхон	21	21	824500	21	21	824500
13	Өвөрхангай	4	3	37815	4	3	38961
14	Өмнөговь	1	1	21789.7	1	1	10663.1
15	Сүхбаатар	1	1	3500	1	1	3500
16	Сэлэнгэ	8	8	233493	8	8	176134
17	Төв	-	-	-	-	-	-
18	Увс	1	1	49774.7	-	-	-
19	Ховд	-	-	-	-	-	-
20	Хөвсгөл	1	1	47417.5	1	1	47417.5
21	Хэнтий	1	-	-	-	-	-
22	Улаанбаатар	398	346	2574197	384	30	3264857
	НИЙТ	501	426	5029924	471	115	5445151

2013 оны байдлаар улсын хэмжээнд 471 СӨХ үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь өмнөх онохоос 30-аар хорогдсон үзүүлэлт болно.


2013 онд нийслэлийн хэмжээнд 384 СӨХ үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнээс 30 СӨХ орчны газраа ашиглахаар хүсэлтээ гаргаснаас 30 СӨХ-ны орчны газрыг нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажуулсан байна.

Хүснэгт 1.7.2: СӨХ-ны орчны газрын баталгаажилтын явц /Нийслэлийн хэмжээнд/

д/д	Дүүрэг	Нийт СӨХ-ын тоо	Тоолгогч хамрагдсан СӨХ-ны тоо	Газар ашиглахаар хүсэлт гаргасан СӨХ-ны тоо	Нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажсан	Үүнээс					
						Захирамжаар баталгаажигдсан СӨХ-ээс газар ашиглах эрхийн гэрээ байгуулсан	Нийт СӨХ-ны ашиглаж байгаа талбайн хэмжээ /м2/	Маргаантай болон судлаж байгаа	Захираж гарахаар хүлээгдэж байгаа	Ерөнхий төлөвлөгөө хийгдэж байгаа СӨХ-ийн тоо	Ерөнхий төлөвлөгөө хийгдсэн СӨХ-ийн тоо
1	Сүхбаатар	87	87	3	3	3	785228				
2	Сонгинохайрхан	29	29				361506				
3	Баянзүрх	65	65	2	2	2	538732				
4	Баянгол	105	105				795892				
5	Хан-Уул	47	47	19	19	19	274845				
6	Чингэлтэй	39	39				404254	1			
7	Багануур	4	4				Баталгаажаагүй байгаа				
8	Налайх	6	6	6	6	6	104400				3
9	Багахангай	2	2				Баталгаажаагүй байгаа				
ДҮН		384	384	30	30	30	3264857	1	0	0	0

1.8. ГАЗРЫН КАДАСТРЫН СУДАЛГАА, ХЭМЖИЛ, ЗУРАГЛАЛ ГҮЙЦЭТГЭСЭН ТАЛААР

Нийслэлийн хэмжээнд кадастрын зураглалыг тусгай зөвшөөрөл бүхий ААНБ-ууд, Аймгуудийн хэмжээнд 62.4 %-ийг ГХБХБГ, 37.6%-ийг тусгай зөвшөөрөл бүхий ААНБ-ууд гүйцэтгэж байна /Зураг 1.8.1/.



Зураг 1.8.1: Кадастрын зураглалыг гүйцэтгэж буй ААНБ-дын харьцаа

2012 онд улсын хэмжээнд 433233 нэгж талбар газрын улсын бүртгэлд бүртгэгдсэн ба 2013 онд 47271 нэгж талбар болж 38938-аар нэмэгдсэн байна. 21 аймгийн хэмжээнд геодезийн цэг тэмдэгтийн тоо 4391 байснаас 4352 болж 39-өөр буурсан байна.

1.9. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН 2013 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Аймаг, нийслэл, сум дүүргийн газрын асуудал хариуцсан байгууллага, албан тушаалтнууд нь тайлант онд ГХБГЗЗГ-ын даргын 2010 оны 11 дүгээр сарын 08-ны 497 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу иргэдийн оролцоог хангаж доороос дээш төлөвлөх зарчмаар, нэгдсэн арга зүйгээр боловсруулж батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

Газар зохион байгуулалтын 2013 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн зарим гол үзүүлэлтүүд:

1.Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх ажлын хүрээнд:

- Улсын хэмжээгээр гэр бүлийн хэрэгцээнд одоо эзэмшиж байгаа хашааны 2114.18 га газрыг өмчлүүлэхээр төлөвлөснөөс 1360.09 га хашааны газрыг өмчлүүлж хэрэгжилт 64.33 хувьтай байна. Тухайн жилд Төв, Хөвсгөл аймгууд тэргүүлсэн байна.
- Улсын хэмжээгээр гэр бүлийн хэрэгцээнд шинээр шинэ байршилд 4863.48 га газрыг өмчлүүлэхээр төлөвлөснөөс 2129.25 га хашааны газрыг өмчлүүлж хэрэгжилт 43.79 хувьтай байна. Тухайн жилд Сэлэнгэ, Дорнод аймгууд тэргүүлсэн байна.

2.Улсын хэмжээнд дуудлага худалдаа, давуу эрхээр газар өмчлүүлэх, эзэмшүүлэх ажлын хүрээнд:

- Аж ахуйн зориулалтаар үнээр өмчлүүлэхээр 266.36 газар төлөвлөснөөс 130.17 га газар дуудлага худалдаагаар өмчлүүлж, хэрэгжилт 48.87 хувьтай байна. Дуудлага худалдаа явуулсан үзүүлэлтээр Увс, Сэлэнгэ аймаг тэргүүлсэн байна.
- Тариалангийн зориулалтаар дуудлага худалдаагаар эзэмшүүлэхээр 32700.60 га газар төлөвлөснөөс 14526.10 га газрыг эзэмшүүлж хэрэгжилт 44.42 хувьтай байна. Тариалангийн зориулалтаар дуудлага худалдаа явуулсан үзүүлэлтээр Дорнод, Сүхбаатар аймаг тэргүүлсэн байна.

- Тариалангийн зориулалтаар давуу эрхээр эзэмшүүлэхээр 15943.33 га газар төлөвлөснөөс 5391.42 га тариалангийн газар давуу эрхээр эзэмшүүлж хэрэгжилт 33.84 хувьтай байна. Төв Хэнтий аймгууд тэргүүлсэн байна.
- Жимс, жимсгэнэ, мод бут тарих зориулалтаар 1211.76 га эзэмшүүлэхээр төлөвлөснөөс 524.46 га газар эзэмшүүлж хэрэгжилт 43.28 хувьтай байна.Төв, Булган аймгууд тэргүүлсэн байна.

3.Хууль бус эзэмшилд байгаа 7252.51 га газрыг чөлөөлөхөөр төлөвлөснөөс 7225.37 га газрыг чөлөөлж, хэрэгжилт 99.63 хувьтай байна. Төв, Сэлэнгэ аймгууд тэргүүлсэн байна

4.Төмс хүнсний ногооны зориулалтаар гэр бүлийн хэрэгцээнд 2502.31 га газрыг эзэмшүүлэхээр төлөвлөснөөс 1065.83 га газрыг эзэмшүүлж хэрэгжилт 42.59 хувьтай байна. Сэлэнгэ, Баянхонгор аймаг тэргүүлсэн байна.

5. МAA-н фермерийн зориулалтаар эзэмшүүлэхээр 233.69 га газар төлөвлөснөөс 64.89 га газар эзэмшүүлж хэрэгжилт 27.77 хувьтай байна. Төв, Булган аймаг тэргүүлж байна.

6.Аялал жуулчлалын зориулалтаар эзэмшүүлэхээр 911.66 га газар төлөвлөснөөс 291.35 га газар эзэмшүүлж 31.96 хувьтай байна. Баянхонгор, Хөвсгөл аймгууд тэргүүлсэн байна.

2

ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ТАЙЛАН






2.1. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ҮНДСЭН АНГИЛАЛ, ГАЗАР АШИГЛАЛТЫН ТӨРӨЛД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ, ШИЛЖИЛТИЙН ҮНДЭСЛЭЛ /МАЯГТ ГТ-1, 5/

2013 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын газрын нэгдмэл санд хөдөө аж ахуйн газар

115361.3 мянган га буюу 73.76 хувь, хот, тосгон бусад суурины газар 699.5 мянган га буюу 0.45 хувь, зам, шугам сүлжээний газар 437.3 мянган га буюу 0.28 хувь, ойн сан бүхий газар 14295.4 мянган га буюу 9.14 хувь, усны сан бүхий газар 686.6 мянган га буюу 0.44 хувь, улсын тусгай хэрэгцээний газар 24931.1 мянган га буюу 15.94 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.1/.



Зураг 2.1.1: Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалын тус бүрийн эзлэх хувь

2012 оны газрын нэгдмэл сангийн тайлангийн дүнтэй харьцуулахад хөдөө аж ахуйн газар 38.5 мянган га, хот тосгон, бусад суурины газар 2.4 мянган га-аар тус тус хасагдаж, зам, шугам

сүлжээний газар 2.1 мянган га, ойн сан бүхий газар 38.8 мянган га-гаар тус тус нэмэгдэж, улсын тусгай хэрэгцээний болон усны сан бүхий газарт өөрчлөлт ороогүй байна /Хүснэгт 2.1.1/.

Хүснэгт 2.1.1: Улсын газрын нэгдмэл сангийн ангиллын өөрчлөлтийн товчоо /мян.га/


№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2012	2013	Зөрүү / мян га/
I	Хөдөө аж ахуйн газар	115399.9	115361.4	-38.5
1	Бэлчээрийн газар	111032.5	111026.1	-6.4
2	Хадлангийн талбай	1712.3	1712.3	0.0
3	Тариалангийн газар	1031.1	986.8	-44.3
4	Атаршсан газар	292.0	304.9	12.9
5	ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газар	70.3	71.4	1.1
6	ХАА-н хэрэгцээнд тохиромжгүй газар	1261.6	1259.7	-1.9
II	Хот, тосгон бусад суурины газар	702.0	699.6	-2.4
7	Барилга, байгууламжийн дэвсгэр газар	86.6	73.1	-13.5
8	Нийтийн эдэлбэр газар	318.1	330.1	12.0
9	Үйлдвэрийн газар	31.1	40.4	9.3
10	Уурхайн газар	215.1	200.9	-14.2
11	Гэр хорооллын газар	51.2	54.5	3.3
III	Зам, шугам сүлжээний газар	435.2	437.3	2.1
12	Авто замын газар	319.1	319.7	0.6
13	Төмөр замын газар	27.8	27.8	0.0
14	Агаарын тээврийн газар	9.0	8.8	-0.2
15	Шугам сүлжээний газар	79.3	80.8	1.5
16	Усан тээврийн буудлын газар	0.0	0.0	0.0
IV	Ойн сан бүхий газар	14256.6	14295.4	38.8
17	Ой модоор бүрхэгдсэн газар	12100.9	12138.6	37.7
18	Ой модыг нь огтолсон газар	142.2	142.4	0.2
19	Мод үржүүлгийн газар	45.6	46.5	0.9
20	Ой тэлэн ургах нөөц газар	755.1	744.0	-11.1
21	Ойн сангийн бусад газар	1212.7	1223.7	11.0
V	Усны сан бүхий газар	686.8	686.8	0.0
22	Гол мөрний эзлэх газар	228.6	228.5	-0.1
23	Нуур, цөөрөм, тойрмын эзлэх газар	444.7	444.7	0.0
25	Горхи, булаг, шандны эзлэх газар	12.4	12.4	0.0
24	Мөнх цас, мөсөн голын эзлэх газар	1.1	1.1	0.0
VI	Улсын тусгай хэрэгцээний газар	24931.1	24931.1	0.0
26	Улсын тусгай хамгаалалттай газар	20948.3	20948.3	0.0
27	Улсын хилийн зурвас газар	3111.9	3111.9	0.0
28	Улсын батлан хамгаалах зориулалтын газар	124.1	124.1	0.0
29	Гадаадын дипломат, консул, төлөөлөгчийн газар	0.0	0.0	0.0
30	ШУ, туршилт, цаг уурын ажиглалтын талбай	22.9	22.9	0.0
31	Аймаг дундын отрын бэлчээр	586.2	586.2	0.0
32	Улсын тэжээлийн сангийн хадлангийн газар	110.9	110.9	0.0
33	Газрын тосны гэрээт талбай	24.4	24.4	0.0
34	Чөлөөт бүсийн газар	2.1	2.1	0.0
	НИЙТ ДҮН	156411.5	156411.5	0.0

2.1.1. ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

Хөдөө аж ахуйн газар 115361.3 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 73.76 хувийг эзэлж байна.

Хөдөө аж ахуйн газарт бэлчээр 111026.1 мянган га буюу 96.24 хувь, хадлан 1712.3 мянган га буюу

1.48 хувь, тариалан 986.8 мянган га буюу 0.86 хувь, атаршсан газар 304.9 мянган га буюу 0.26 хувь, хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн дэвсгэр газар 71.4 мянган га буюу 0.06 хувь, хөдөө аж ахуйн хэрэгцээнд тохиромжгүй газар 1259.7 мянган га буюу 1.09 хувийг тус тус эзэлж байна. /Зураг2.1.1.1/.



Зураг 2.1.1.1: Хөдөө аж ахуйн газрын ангиллын эзлэх хувь

Бэлчээрийн газар

Бэлчээрийн газар нь 2012 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 6.4 мянган га-аар хасагдсан байна. Үүнээс:

Хүснэгт 2.1.1.1: Бэлчээрийн газраас бусад ангилал руу шилжсэн байдал

№	Шилжсэн газрын нэгдмэл сангийн ангилал	Нэмэгдсэн талбай /мян.га/
I	Хөдөө аж ахуйн газар	1.13
1	Хадлангийн талбай	0.02
2	ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газар	1.11
II	Хот, тосгон бусад суурины газар	0.94
3	Нийтийн эдэлбэр газар	0.71
4	Үйлдвэрийн газар	0.11
5	Уурхайн газар	0.12
III	Зам, шугам сүлжээний газар	2.15
6	Авто замын газар	0.66
7	Шугам сүлжээний газар	1.49
IV	Ойн сан бүхий газар	1.94
8	Ой модоор бүрхэгдсэн газар	1.79
9	Мод үржүүлгийн газар	0.16
	НИЙТ ДҮН	6.16

Хадлангийн газар

Хадлангийн газар нь 2012 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 0.2 мянган га-аар нэмэгдсэн байна.

Малын тоо толгойн өсөлт, бэлчээрийн ургац муудаж байгаатай холбоотойгоор хадлангийн талбай ашиглах, усалж тордох бордох боломж бүхий талбайнуудыг хашиж хамгаалан байнгын хадлангийн талбайтай болох зорилгоор Говь-Алтай, Завхан, Увс, аймгуудад хадлангийн газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшилд олгосноор хадлангийн талбайн хэмжээ эдгээр аймгуудад нийтдээ 0.4 га-аар нэмэгдсэнээр улсын хэмжээнд нийт дүнгээрээ нэмэгдсэн байна.

Тариалангийн газар


Тариалангийн газар нь 2012 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 44.3 мянган га-аар хасагдсан байна.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Амгалан тал гэдэг газар 10000 га газрыг атаршсан газраас хасан тариалангийн талбайд шилжүүлсэн байна.

Дорнод аймгийн Хөлөнбуйр суманд хууль бусаар олгогдсон 20 мянган тариалангийн газрыг эргүүлэн бэлчээрийн газарт шилжүүлсэн байна. Мөн тус аймагт "Инженер геодези" ХХК-ны гүйцэтгэсэн аймгийн ерөнхий төлөвгөөний ажлын хүрээнд Баяндун сум 624.36 га, Баянтүмэн сум 36.5 га, Булган сум 3255.9 га, Баян-Уул сум 9020.06 га, Хөлөнбуйр сум 334.76 га, Сэргэлэн сум 1876.2 га, Цагаан-Овоо сум 3442 га, Чойбалсан сум 4415 гаашиглагдахгүй байсан тариалангийн газруудыг атаршсан газарт шилжүүлсэн байна.

Хүснэгт 2.1.1.2: Тариалангийн газрын өөрчлөлтийн товчоо /га/

№	Аймгийн нэр	2012	2013	Зөрүү /га/
1	Архангай	23483.44	23726.74	243.3
2	Баянхонгор	1858.25	1877.15	18.9
3	Баян-Өлгий	1696.2	1207.40	-488.8
4	Булган	72665.98	71156.49	-1509.49
5	Говь-Алтай	4869.58	4894.68	25.1
6	Говьсүмбэр	385.02	381.02	-4
7	Дархан-Уул	34819.14	34634.24	-184.9
8	Дорнод	141940.5	87420.59	-54519.9
9	Дорноговь	375.995	377.50	1.5
10	Дундговь	689.72	688.82	-0.9
11	Завхан	1923.17	1756.77	-166.4
12	Орхон	4938.55	4938.00	-0.55
13	Өвөрхангай	15552.95	15712.86	159.91
14	Өмнөговь	726.49	815.44	88.95
15	Сүхбаатар	115.7113	14717.71	14602
16	Сэлэнгэ	313705.5	313979.23	273.73
17	Төв	255261.5	251295.81	-3965.69
18	Увс	44222.9	46556.94	2334.04
19	Ховд	8217.37	8164.85	-52.52
20	Хөвсгөл	32667.98	33266.68	598.7
21	Хэнтий	63980	62205.20	-1774.8
22	Улаанбаатар	7003.38	7059.38	56
Нийт дүн		1031099	986833.50	-44265.5




Зураг 2.1.1.3: Тариалангийн газрын өөрчлөлт /мян.га/

Атаршсан газар

Атаршсан газар нь 2012 оны тайлангийн дүнтэй харьцуулахад 12.9 мянган га-аар нэмэгдсэн байна.

2013 онд тариалангийн газраас 57.5 мянган га талбайг атаршуулсан байна. Үүнд Дорнод аймгийн нийт 8 сумдад 23.0 мянган га талбайг тариалангийн газраас хасаж атаршсан газарт шилжүүлсэн нь дийлэнх хувийг эзэлжээ.




Зураг 2.1.1.4: Атаршсан газрын хэмжээг оноор харьцуулсан байдал

2.1.2. ХОТ, ТОСГОН, БУСАД СУУРИНЫ ГАЗАР

Хот, тосгон бусад суурины газар 699.5 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 0.45 хувийг эзэлж байна.

Хот, тосгон, бусад суурины газарт барилга, байгууламжийн дэвсгэр газар 73.1 мянган га буюу 10.46 хувийг, нийтийн эдэлбэрийн газар 330.2 мянган га буюу 47.21 хувийг, үйлдвэрийн газар 40.4 мянган га буюу 5.79 хувийг, уурхайн газар 200.9 мянган га буюу 28.73 хувийг, гэр хорооллын газар 54.5 мянган га буюу 7.81 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.2.1/.



Зураг 2.1.2.1: Хот, тосгон, бусад суурины газрын ангилалын эзлэх хувь


Хүснэгт 2.1.2.1: Хот, тосгон, бусад суурин газрын өөрчлөлт

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2012	2013	Зөрүү
II	Хот, тосгон бусад суурины газар	702.0	699.6	-2.4
1	Барилга, байгууламжийн дэвсгэр газар	86.6	73.1	-13.5
2	Нийтийн эдэлбэр газар	318.1	330.1	12.0
3	Үйлдвэрийн газар	31.1	40.4	9.3
4	Уурхайн газар	215.1	200.9	-14.2
5	Гэр хорооллын газар	51.2	54.5	3.3

2.1.3. ЗАМ, ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ГАЗАР

Зам, шугам сүлжээний газар 437.3 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 0.28 хувийг эзэлж байна.

Зам, шугам сүлжээний газарт автозамын газар 319.7 мянган га буюу 73 хувийг, төмөр замын доорх газар 27.8 мянган га буюу 6 хувийг, агаарын тээврийн газар 8.8 мянган га буюу 2 хувийг, шугам сүлжээний газар 80.8 мянган га буюу 19 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.3.1/.



Зураг 2.1.3.1: Зам, шугам сүлжээний газрын ангил тус бүрийн эзлэх хувь


Хүснэгт 2.1.3.1: Зам, шугам, сүлжээний газрын ангиллын өөрчлөлт /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2012	2013	Зөрүү
III	Зам, шугам сүлжээний газар	435.2	437.3	2.1
1	Авто замын газар	319.1	319.7	0.6
2	Төмөр замын газар	27.8	27.8	0.0
3	Агаарын тээврийн газар	9.0	8.8	-0.2
4	Шугам сүлжээний газар	79.3	80.8	1.5
5	Усан тээврийн буудлын газар	0.0	0.0	0.0

2.1.4. ОЙН САН БҮХИЙ ГАЗАР

Ойн сан бүхий газар 14295.4 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 9.14 хувийг эзэлж байна.

Ойн сан бүхий газарт ойгоор бүрхэгдсэн газар 12138.6 мянган га буюу 84.91 хувийг, ой модыг нь огтолсон газар 142.4 мянган га буюу 1 хувийг, мод үржүүлгийн газар 46.5 мянган га буюу 0.33 хувийг, ой тэлэн ургах нөөц газар 744.0 мянган га буюу 5.2 хувийг, ойн сангийн бусад газар 1223.7 мянган га буюу 8.56 хувийг тус тус эзэлж байна /Зураг2.1.4.1/.



Зураг 2.1.4.1: Ойн сан бүхий газрын ангиллын эзлэх хувь


Хүснэгт 2.1.4.1: Ойн сан бүхий газрын өөрчлөлт /мян.га/

№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2012	2013	Зөрүү
IV	Ойн сан бүхий газар	14256.6	14295.4	38.8
1	Ой модоор бүрхэгдсэн газар	12100.9	12138.6	37.7
2	Ой модыг нь огтолсон газар	142.2	142.4	0.2
3	Мод үржүүлгийн газар	45.6	46.5	0.9
4	Ой тэлэн ургах нөөц газар	755.1	744.0	-11.1
5	Ойн сангийн бусад газар	1212.7	1223.7	11.0

2.1.5. УСНЫ САН БҮХИЙ ГАЗАР

Усны сан бүхий газар 686.6 мянган га буюу нийт газар нутгийн 0.44хувийг эзэлж байна.

Усны сан бүхий газарт мөрөн, гол, горхи 228.4 мянган га буюу 33.27 хувийг, нуур, цөөрөм 444.6 мянган га буюу 64.75 хувийг, цас, булаг, шанд 12.4 мянган га буюу 1.81 хувийг мөсөн гол 1.1 мянган га буюу 0.17 хувийг тус тус эзэлж байна /Зураг 2.1.5.1/.




Зураг 2.1.5.1: Усны сан бүхий газрын ангиллын эзлэх хувь

2.1.6. УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР /МАЯГТ ГТ-4/

Улсын тусгай хэрэгцээний газар 24931.1 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 15.94 хувийг эзэлж байна.

Улсын тусгай хэрэгцээний газрын ангилалд улсын тусгай хамгаалалттай газар 20948.3 мянган га буюу 84.0 хувийг, улсын хилийн зурвас газар 3112,0 мянган га буюу 13.0 хувийг, улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар 124,1 мянган га буюу 1.0 хувийг, гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар,

олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар 0,027 мянган га буюу 0.001 хувийг, шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай 22.9 мянган га буюу 0.009 хувийг, аймаг дундын отрын бэлчээр 586.2 мянган га буюу 2.0 хувийг, улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай 110.9 мянган га буюу 0.4 хувийг, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай 24,5 мянган га буюу 0.1 хувийг, чөлөөт бүсийн газар 2,1 мянган га буюу 0.008 хувийг тус тус эзэлж байна.



Зураг 2.1.6.1: Улсын тусгай хэрэгцээний газрын ангиллын талбайн хэмжээ /га-гаар/

Хүснэгт 2.1.6.1: Улсын тусгай хэрэгцээний газрын өөрчлөлт /мян.га/


№	Газрын нэгдмэл сангийн ангилал	2012	2013	Зөрүү
1	Улсын тусгай хамгаалалттай газар	20948.3	20948.3	0.0
2	Улсын хилийн зурвас газар	3111.9	3111.9	0.0
3	Улсын батлан хамгаалах зориулалтын газар	124.1	124.1	0.0
4	Гадаадын дипломат, консул, төлөөлөгчийн газар	0.0	0.0	0.0
5	ШУ, туршилт, цаг уурын ажиглалтын талбай	22.9	22.9	0.0
6	Аймаг дундын отрын бэлчээр	586.2	586.2	0.0
7	Улсын тэжээлийн сангийн хадлангийн газар	110.9	110.9	0.0
8	Газрын тосны гэрээт талбай	24.4	24.4	0.0
9	Чөлөөт бүсийн газар	2.1	2.1	0.0

Улсын Их Хурлын 2013 оны 52 дугаар тогтоолоор Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Бүгд Найрамдах Турк Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамдын

одоо ашиглаж буй 1.18 га газрыг тус улсын тусгай хэрэгцээнд авсаны дагуу өөрчлөлтийг ГТ-4 тайланд тусгав.


2.2. ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-2/

2013 онд улсын хэмжээнд нийт 5536369.4 га газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгоод байна. Үүнээс 40419.0 га-г өмчилж, 5304797.8 га-г эзэмшиж, 175579.9 га газрыг ашиглаж байна. Мөн бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллага 15572.7 га газрыг тус тус ашиглаж байна /Зураг 2.2.1/.




Зураг 2.2.1: 2013 оны байдлаар өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа газар /га-гаар/

Тайлант оны газар, өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн нийт талбайг 2012 онтой харьцуулбал 226335.3 га-гаар өссөн байна /Зураг 2.2.2/.




Зураг 2.2.2: Нийт өмчлөл, эзэмшил, ашиглалтанд буй газрыг урьд оны дүнтэй харьцуулсан байдал /га-гаар/


Газрын эрхийн төрлөөр 2012 оны үзүүлэлттэй харьцуулахад иргэний өмчлөлийн газар 40419.0 га болж 3944.6 га-аар /Зураг 2.2.3/, иргэн, хуулийн этгээдийн эзэмшлийн газар 5304797.8 га болж 170355.6 га-аар /Зураг 2.2.4/, иргэн, хуулийн этгээдийн ашиглаж буй газар 175579.9 га болж 52908.1 га-гаар /Зураг 2.2.6/ тус тус өссөн бол бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар 15572.7 га болж 873 га-гаар /Зураг 2.2.5/ буурсан дүнтэй байна /Зураг 6/.




Зураг 2.2.3: Газар өмчлөгч /га-гаар/



Зураг 2.2.4: Газар эзэмшигч /га-гаар/



Зураг 2.2.5: Бусдын эзэмшил газрыг ашиглагч




Зураг 2.2.6: Газар ашиглагч /га/

Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага /га-гаар/

Газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангиллаар авч үзвэл хөдөө аж ахуйн газарт 1168465.8га, хот тосгон, бусад суурины газарт 402093.7 га, зам, шугам сүлжээний газарт 150804.5 га, ойн сан бүхий

газарт 672323.5 га, усны сан бүхий газарт 84203.4 га, улсын тусгай хэрэгцээний газарт 3058478.6 га газар өмчлөл, эзэмшил, ашиглалтанд олгогдоод байна / Зураг 2.2.7/.




Зураг 2.2.7: Нийт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдыг газрын нэгдмэл сангийн ангиллаар үзүүлсэн байдал /хувиар/

Хүснэгт 2.2.1: Газрын нэгдмэл сангийн ангилал дахь эрхийн төрлийн өөрчлөлт

д/д	Газрын нэгдмэл сангийн ангилал	Эрхийн төрөл	2012	2013	Зөрүү
1	Хөдөө аж ахуйн газар	өмчлөгч	40.9	51.4	10.5
		эзэмшигч	1187143.0	1152870.4	-34272.6
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	7260.1	7266.1	6.0
		ашиглагч	18387.6	8278.0	-10109.6
		нийт	1212831.5	1168465.9	-44365.6
2	Хот, тосгон, бусад суурины газар	өмчлөгч	36433.5	40367.7	3934.2
		эзэмшигч	250301.8	287713.2	37411.4
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	5270.9	5265.9	-5.0
		ашиглагч	71025.6	68747.0	-2278.6
		нийт	363031.7	402093.8	39062.1
3	Зам, шугам шүлжээний газар	эзэмшигч	128739.2	140139.2	11400.0
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	3588.9	2714.8	-874.1
		ашиглагч	6655.1	7950.5	1295.4
		нийт	138983.2	150804.5	11821.3
4	Ойн сан бүхий газар	эзэмшигч	635702.3	672277.0	36574.7
		ашиглагч	46.5	46.5	0.0
		нийт	635748.8	672323.5	36574.7
5	Усны сан бүхий газар	эзэмшигч	31175.4	82120.1	50944.7
		ашиглагч	2083.3	2083.3	0.0
		нийт	33258.7	84203.4	50944.7
6	Улсын тусгай хэрэгцээний газар	эзэмшигч	2901380.5	2969678.0	68297.5
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	325.9	325.9	0.0
		ашиглагч	24473.7	88474.6	64000.9
		нийт	2926180.1	3058478.5	132298.4


2.3. ГАЗРЫН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-3/

Тус тайлангаар улсын хэмжээнд нийт 721670 газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч байгаа нь өмнөх оныхоос нийт дүнгээрээ 29450-иар өссөн байна /Зураг2.3.3/.




Зураг 2.3.3: Нийт өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдыг урьд оны дүнтэй харьцуулсан байдал /тоогоор/

Тайлант онд газар өмчлөгч 371978, эзэмшигч 348160, бусдын эзэмшил газрыг ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 912, газар ашиглагч 620 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тус тус байна /Зураг 2.3.4/.




- Газар өмчлөгч
- Газар эзэмшигч
- Бусдын эзэмшил газрыг ашиглагч
- Газар ашиглагч


Зураг 2.3.4: Нийт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчид /тоо, эзлэх хувь/




Зураг 2.3.5: Газар өмчлөгч /тоогоор/



Зураг 2.3.6: Газар эзэмшигч/тоогоор/



Зураг 2.3.7: Бусдын эзэмшил газрыг ашиглагч




Зураг2.3.8: Газар ашиглагч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага /тоогоор/

Төв аймагт 2013 онд “Газрын тухай хууль”-ийн 40 дүгээр зүйлийн 40.1.6-д заасны дагуу тус аймгийн нийт 22 суманд 15.8 мянган га газрыг эзэмшигч 1072 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших

эрхийг хүчингүй болгосон. Мөн тус аймгийн Засаг даргын 2013 оны А/448 тоот захирамжийн хүрээнд 2003 оноос хойш “Газрын тухай хууль”-ийн 33.1.2 дахь заалтыг зөрчин дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтгүйгээр олгосон 8 сумын 145 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил 7184.04 га газрын газар эзэмших эрхийг хүчингүй болгож, “Газрын тухай хууль” тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажилласан, мөн нийслэлд хууль зөрчиж олгогдсон болон газрын зөрчил маргааны улмаас нийслэлийн Засаг даргын захирамжаар газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг хүчингүй болгосны улмаас газар эзэмшигч, ашиглагчдын тоон үзүүлэлт улсын хэмжээнд нийт дүнгээрээ буурсан үзүүлэлттэй байна.

Нийт газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдыг газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангиллаар үзүүлбэл хөдөө аж ахуйн газарт 168498, хот тосгон, бусад суурины газарт 547066, зам, шугам сүлжээний газарт 1542, ойн сан бүхий газарт 3019, усны сан бүхий газарт 39, улсын тусгай хэрэгцээний газарт 1506 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар эзэмшиж, ашиглаж байна /Зураг 2.3.9/.



Зураг2.3.9: Газрын нэгдмэл сангийн ангиллаар үзүүлсэн байдал /тоогоор/

Хүснэгт 2.3.1: Газар эзэмшигч, ашиглагчдын өөрчлөлт /газрын нэгдмэл сангийн ангиллаар/


д/д	Газрын нэгдмэл сангийн ангилал	Эрхийн төрөл	2012	2013	Зөрүү
1	Хөдөө аж ахуйн газар	өмчлөгч	62	82	20
		эзэмшигч	164576	168326	3750
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	48	53	5
		ашиглагч	36	37	1
		нийт	164722	168498	3776
2	Хот, тосгон, бусад суурины газар	өмчлөгч	330178	371896	41718
		эзэмшигч	191108	174490	-16618
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	176	177	1
		ашиглагч	562	503	-59
		нийт	522024	547066	25042
3	Зам, шугам шүлжээний газар	эзэмшигч	1433	1473	40
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	11	6	-5
		ашиглагч	55	63	8
		нийт	1499	1542	43
4	Ойн сан бүхий газар	эзэмшигч	2338	3016	678
		ашиглагч	3	3	0
		нийт	2341	3019	678
5	Усны сан бүхий газар	эзэмшигч	41	36	-5
		ашиглагч	3	3	0
		нийт	44	39	-5
6	Улсын тусгай хэрэгцээний газар	эзэмшигч	962	819	-143
		бусдын эзэмшил газрыг ашиглагч	617	676	59
		ашиглагч	5	11	6
		нийт	1584	1506	-78

2.4. ГАЗАРТ УЧРУУЛСАН ХОХИРЛЫН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-6/

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл зонхилсон, хуурай бүс нутагт оршдог манай оронд уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн талхлагдал, тариалангийн хөрсний үржил шимийн бууралт, ойн түймэр, хортон шавьж, модны замбараагүй хэрэглээ, уул уурхайн зохисгүй үйл ажиллагаанаас үүдэлтэй газрын доройтол, цөлжилт ихээхэн явагдаж байна. Энэхүү доройтлыг “газарт учруулсан хохирол”

гэсэн томъёололд хамааруулан хохирлын хэмжээг дэлгэрэнгүй үзүүлэлт /ГТ-6 маягт/-үүдээр хүлээн авч, улсын хэмжээнд нэгтгэн дүгнэв.

Улсын хэмжээнд газарт учруулсан хохиролын тайланг ГТ-6 маягтын дагуу дэлгэрэнгүй байдлаар хүлээн авч нэгтгэхэд улсын хэмжээнд тариалангийн 39072.1 га, бэлчээр ба бусад өвслөг ургамалт газарт 8804182 га, хот тосгон, бусад суурин газарт 6582.2 га, ойн сан бүхий газарт 153799.3 га, усны сан бүхий газарт 533.9 га, ухагдаж эвдэрсэн газрын хэмжээ 10487.8 га байна /Зураг 2.4.1/.



Зураг 2.4.1: Газарт учруулсан хохирлын зураг /аймгаар/

Газарт учруулсан хохирлыг газрын нэгдмэл сангийн ангиллын газруудаар авч үзэхэд дараах байдалтай байна.


Тариалангийн газар

Тариалангийн талбай салхины эвдрэлд орох, үржил шим нь буурах, мэрэгчид, хортон шавьжид нэрвэгдэх зэргээр манай орны нийт хөрсний ялзмагийн агууламж буурч ургамалд ашигтай тэжээлийн химийн элементүүд багасаж байна.

Тариалангийн газрын хохирол, доройтлыг салхи, усны элэгдэл эвдрэлд орсон, үржил шимийн

бууралттай, хортон шавьжид нэрвэгдсэн, хөрс бохирдсон, химийн бодисоор бохирдсон болон бусад гэсэн үзүүлэлтүүдээр ангилан гаргахад улсын хэмжээнд нийт 39.0 мян.га буюу урьд оныхоос 5.7 мян.га буюу 12,7 хувиар багасчээ.

Үүнээс хамгийн их 41.1 хувь буюу 16072.9 га талбайн үржил шим буурсан, 20.3 хувь буюу 7942.6 га талбай мэрэгчид, хортон шавьжинд идэгдсэн, 21.5 хувь буюу 8428.6 га салхины эвдрэлтэй, 12.8 хувь буюу 5017 га усны эвдрэлтэй, 3.1 хувь буюу 1241 га талбайн хөрс бохирдсон, 370 га талбай бусад төрлийн хохирол тус тус учирсан байна /Зураг 2.4.2/.



Зураг 2.4.2: Тариалангийн газарт учирсан хохирлын төрөл, хувь

Тариалангийн газарт учирсан хохирлын хэмжээ нь улсын хэмжээнд хохирол учирсан нийт талбайтай харьцуулахад 0.43 хувь нь болж байна.

Тариалангийн газарт учирсан хохирлын хэмжээ, төрөл нь бүс нутгуудад ялгаатай байгаа боловч өмнөх жилээс буурсан нь Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөр”, “Атрын-III аян”-ы хүрээнд зохион байгуулсан арга хэмжээнүүдийн үр дүн гэж үзэж болохоор байна. Сүүлийн 20-иод жил уналтад орсон газар тариалангийн үйлдвэрлэл сэргэж, атаршсан талбайн хэмжээ буурч, тариалангийн газрын ашиглалт сайжирсан нь дээрхи мэдээнээс харагдаж байна.

Газар тариалангийн гол бус болох Сэлэнгэ, Хөвсгөл, Өвөрхангай аймгууд хамгийн их буюу 5.5-9.8 мян.га талбайд хохирол учирсан байна. Тариалангийн талбайн хохиролын гол шалтгаан нь уржил шимийн бууралт, мэрэгчид, хортон шавьжинд нэрвэгдэх байдал болж байна.

Бэлчээрийн газар

Бэлчээрт учирсан хохиролын дүн мэдээг улсын хэмжээнд авч үзэхэд 2013 оны байдлаар бэлчээр ба өвслөг ургамалтай газарт 8.8 сая га бэлчээр хохиролд өртсөн нь газарт учирсан нийт хохирлын дийлэнх буюу 97.6 хувийг эзлэж байна.

Бэлчээрт учирсан хохиролыг төрлүүдээр нь авч үзвэл 21.2 хувь буюу 1.8 сая га талхлагдсан, 0.1 хувь буюу 11 мян.га нь салхи, усны эвдрэлд орсон, 2.7 хувь буюу 240.7 мян.га элсний нүүлтэд өртсөн, 28.7 хувь буюу 2.5 сая.га мэрэгчид, хортон шавьжид идэгдсэн, 46.6 хувь буюу 4.1 сая.га цөлжсөн, 47.3 мян.га ашигт малтмалын олборлолтоос бохирдсон байна.

Бэлчээрийн газарт учирсан хохирлын хэмжээг зураг 2.4.3-түзүүлэв.



Зураг2.4.3: Бэлчээрт учирсан хохирлын харьцуулалт /оноор/


Бэлчээрийн хохирлын хэмжээг 2012 онтой харьцуулахад салхи, усны эвдрэл 2.6 мян.га, мэрэгчид, хортон шавьжид идэгдсэн 664.9 мян.га, цөлжсөн газрын хэмжээ (түймэрт өртсөн) 1350.1 мян.га-гаар тус тус өссөн, харин талхлагдсангаар 369.3 га, элсний нүүлтэд орсон талбай 143.3 мян.га, ашигт малтмалын олборлолтонд өртсөн талбай 76.7 мян.га-гаар буурсан мэдээ гарлаа.

Талхлагдсан бэлчээрийн хэмжээ бууралтанд өнгөрсөн жилийн хур тунадасны хэмжээ (нийт нутгийн 80 орчим хувь нь зуншлага сайтай) нөлөөлжээ. Энэ оны бэлчээрт учирсан хохирлын хамгийн их хувийг түймэрт өртсөнтэй газар (Дорнод аймагт 3.1 сая га бэлчээр) эзлэж байна.

Хот тосгон, бусад суурин газар

Өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байгаа суурьшил нь нэг талаас газрын гадаргыг ургамлан бүрхэвчгүй болгох, элсний нүүлтийг нэмэгдүүлэх зэргээр түүний орчны доройтлыг ихэсгэж байна. Хөрсөн дээр ургамлан бүрхэвчгүй болоход элсний нүүлт хөдөлгөөн идэвхиждэг. Мөн үйлдвэр, үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаа, иргэн, айл өрхийн ахуйн хэрэглээнээс хог хаягдал, бохирдуулагч бодис зориулалтын бус байгууламжаардамжин агаар мандал, усан орчин, хөрс, газрын хэвлий, орчныг бохирдуулж байна.

Хот тосгон,бусад суурин газарт 6582.2 га талбайд хохирол учирсанаас ургамлан бүрхэвчгүй болсон 1568.2 га, элсний нүүлтэд орсон 809.4 га, үйлдвэрийн хог хаягдлаар бохирдсон 36.5 га, ахуйн хог хаягдлаар бохирдсон 3738.9 га, бусад төрлийн хохирол учирсан 429.2га газар тус тус бүртгэгджээ /2.4.4-р зураг/.



Зураг 2.4.4: Хот, тосгон бусад суурины газарт учирсан хохирол, /аймгуудаар/

Дээрх зургаас харахад Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Өмнөговь, Говьсүмбэр аймгуудын хот тосгон, бусад суурины газар хохиролд ихээхэн өртсөн байна. Дийлэнх аймгуудад ахуйн хог хаягдлаар бохирдсон гэж бүртгэгдсэн бол Хөвсгөл аймагт ургамлан бүрхэвчгүй болсон хот суурины талбай 662.4 га байгаа нь хамгийн их нь юм.

Ойн сан бүхий газар

Манай орны ойн сангийн газарт түймэр ихээр гарах, өвчин, хөнөөлт шавьжинд нэрвэгдэх, ашигт малтмалын олборлолтод өртөх, зөвшөөрөлгүй мод огтлох зэргээр ойнэкосистемийн тэнцвэрт байдал алдагдаж доройтолд орсоор байна.

Ойн сан бүхий газарт 153799.3 мян. га талбайд хохирол учирснаас түймэрт нэрвэгдсэн 37.3 мян.га, өвчин, хортон шавьжид идэгдсэн 85.8 мян.га, ашигт малтмалын олборлолтонд өртсөн 19.1 га, мод бут, сөөг, загийг угтгасан 29.7 мян.га газар тус тус байна.

Хүснэгт 2.4.1: Ойн сан бүхий газарт учирсан хохирлын хэмжээ /мян.га/

Он	Түймэрт нэрвэгдсэн	Өвчин, хортон шавьжид идэгдсэн	Ашигт малтмалын олборлолтод өртсөн	Мод бут, сөөг, загийг устгасан
2009	448,2	255,5	0,04	130,0
2010	67,4	177,1	0,04	131,2
2011	55,5	107,5	111,6	129,8
2012	217,7	63,1	0,04	147,7
2013	37,3	85,8	19,1	29,7

Дийлэнх хохирлын 55.8 хувь нь өвчин хортон, шавьжид идэгдсэн, 24.2 хувь нь түймэрт нэрвэгдсэн 19.3 хувь нь мод, бут, сөөг, загийг нь устгаснаас үүссэн хохирол байна.

2013 онд ойн сан бүхий газарт учирсан хохирлын хэмжээг 2012 оныхтой харьцуулахад түймэрт нэрвэгдсэн талбайн хэмжээ 162.2 мян.га-гаар, мод бут, сөөг загийг нь устгасан ой 17.9 мян.га-гаар нэмэгдсэн бол өвчин, хортон шавьжид идэгдсэн ойн талбай 44.4 мян.га-гаар ашигт малтмалын олборлолтод өртсөн ойн сангийн талбай 111.56 га-гаар тус тус буурчээ./2.4.5-р зураг/.



2.4.5: 2013 онд ойн сан бүхий газарт учирсан хохирлын хэмжээ

Түймэрт шатсан ойгоор Хэнтий, Хөвсгөл, Завхан, Дорнод аймгууд, өвчин хортон шавьжид идэгдсэн ойн талбайгаараа Хэнтий, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Баянхонгор бусад аймгуудаас их хэмжээтэй байна.

Усны сан бүхий газар

Усны сан бүхий газарт нийт 533.9 га хохиролд өртсөнөөс үйлдвэрлэлийн хордолт, бохирдолтод өртсөн эрэг хавийн газар 1.0 га, ашигт малтмалын олборлолтоос хохиролд өртсөн эрэг хавийн газар 329.6 га, бусад шалтгаанаар хохирсон 203.3 га газар бүртгэгджээ.

Өмнөх оны дүнтэй харьцуулж үзэхэд усны сангийн талбайд учирсан хохирол нийт 304.2 га-гаар нэмэгдсэн байна. Улсын хэмжээнд ашигт малтмалын олборлолтоос эвдрэлд өртсөн эрэг хавийн газар, бусад шалтгаанаар хохиролд орсон газар Өмнөговь, Хөвсгөл, Говь-Алтай, Завхан аймагт хамгийн их байна.

Ухагдаж эвдэрсэн газар

Хэдийгээр уул уурхайн салбар Монгол улсын хөгжилд чухал ач холбогдолтой ч газрын доройтлыг бий болгож байгаа үндсэн хүчин зүйлүүдийн нэг юм.

Ашигт малтмал олборлох, барилгын материал бэлтгэх, авто зам тавих, геологийн эрэл хайгуул хийх, барилга байгууламж барих явцад байгалийн хөрсийг хуулах, шороон далан, овоолго бий болгох, шуудуу татах зэргээр газрын төрх байдлыг өөрчилж техникийн гаралтай хөрсний эвдрэл ихээр бий болгож байна. Үүний зэрэгцээ хүнд машин механизмаар эмх замбараагүй олон зам гаргаж, тоос бужигнуулан орчныг их хэмжээгээр доройтуулж, нөхөн сэргээлтийн ажлуудангалттай хэмжээнд хийгдэхгүй байгаа нь доорхи мэдээнээс харагдаж байна.


Ухагдаж эвдэрсэн газар нийт 10487.3 га талбайг эзлэж байгаагаас геологийн эрэл хайгуулын ажлаас 236.8 га, ашигт малтмалын олборлолтоос 8560.6га, батлан хамгаалах аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны улмаас 47.0 га, барилга, инженерийн шугам сүлжээ барих, засвар үйлчилгээ хийх ажлаас

118.9 га, зам тээвэр холбооны барилга засвар үйлчилгээний ажлаас 1524.5 га талбай тус тус эвдэрсэн байна.


Улсын хэмжээнд ашигт малтмалын олборлолтоос эвдэрсэн газар Сэлэнгэ аймагт хамгийн их буюу 2866 га, Төв аймагт 2487.2 га Дархан-Уул аймагт 1015.88 га, Говь-Алтайн аймагт 720 га байна.

2.5. ГАЗАР ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН /МАЯГТ ГТ-7/

Улсын хэмжээнд газар хамгаалах арга хэмжээний тайланг ГТ-7 маягтын дагуу дэлгэрэнгүй байдлаар хүлээн авч нэгтгэхэд, тариалангийн газрын 117.9 мян.га-д, бэлчээр ба бусад өвслөг ургамал бүхий газрын 2301.0 мян.га-д, хот тосгон бусад суурин газрын 11.6 мян. га-д, ойн сан бүхий газрын 165.2 мян.га-д, усны сан бүхий газрын 1.1 мян.га-д, уурхайн эдэлбэр газрын 7.2 мян.га буюу нийт 2604.1 мян.га талбайд хамгаалалтын арга хэмжээ авчээ /2.5.1, 2.5.2-р зураг/.



Зураг2.5.1: Газар хамгаалах арга хэмжээ, газрын нэгдмэл сангийн ангиллын газруудаар, хувь




Зураг 2.5.2: Газар хамгаалах арга хэмжээний тайлангийн зураг

Газар хамгаалах арга хэмжээг авсан газрыг газрын нэгдмэл сангийн ангиллын дагуу авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Тариалангийн газар

Тариалангийн газрын хувьд нийт 117933.6 га талбайд хамгаалах арга хэмжээ авснаас 1500.8 га-д олон наст тариалж, 49112.3 га газрыг зурваслан, 829.0 га газрыг ойн зурвасаар хамгаалан, 25883.4 га-г химийн бордоогоор бордсон, 24917.9 га-г шим ба эрдэс бордоогоор бордож, 15690.1 га талбайн хортон шавьж мэрэгчдийг устгасан байна. /2.5.3-р зураг/




- Олон наст ургамал тарьсан
- Зурваслан тариалсан
- Ойн зурвасаар хамгаалагдсан
- Химийн бордоогоор бордсон
- Шим ба эрдэс бордоогоор бордсон
- Хортон шавьж мэрэгчдийн хөнөөлтэй тэмцсэн

Зураг 2.5.3: Тариалангийн газар хамгаалах арга хэмжээ /хувь/

Бэлчээрийн газар

Бэлчээр ба өвслөг ургамалтай газрын хувьд нийт 2301.0 мян.га талбайг хамгаалсанаас элсний нүүлтээс хамгаалсан талбай 1300.1 га, тордон сайжруулсан 6811.1 га, хортон мэрэгчдийн хөнөөлтэй тэмцсэн 707097.5 га, хог хаягдлаас цэвэрлэсэн 765.2 га, даацыг нь тохируулсан 172721.0 га, ашиглалтаас чөлөөлсөн 410411.5 га, сэлгэж ашигласан 1001909 га талбай байна /2.5.4-р зураг/




- Элсний нүүлтээс хамгаалсан
- Тордон сайжруулсан
- Хортон шавьж мэрэгчдийн хөнөөлтэй тэмцсэн
- Хог хаягдлаас цэвэрлэсэн
- Даацыг тохируулсан
- Ашиглалтаас чөлөөлсөн
- Сэлгэж ашигласан

Зураг 2.5.4: Бэлчээр ба бусад өвслөг ургамалт газар хамгаалах арга хэмжээ /хувь/

Хот, тосгон, бусад суурины газар

Хот, тосгон, бусад суурины газрын хувьд нийт 11652.6 га талбайд хамгаалах арга хэмжээ авснаас хөрсжүүлэн зүлэгжүүлсэн 68.3 га, мод бут сөөг тарьсан 2370.7 га, далан хаалтаар хамгаалсан 24.7 га, нүх жалгыг тэгшилж янзалсан 233.9 га, ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлаас цэвэрлэсэн 980.1 га, элсний нүүлтээс хамгаалсан 49.1 гаталбай тус тус эзлэж байна/Зураг 2.5.5/.



Зураг 2.5.5: Хот, тосгон бусад суурины газар хамгаалах арга хэмжээ /хувь/

Ойн сан бүхий газар

Ойн сан бүхий газарт нийт 165260.6 га талбайд хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авчээ. Тухайлбал 6684.2 га ойд цэвэрлэгээ хийж, 3402.3 га талбайд ойн өвчин, хортон шавьжтай тэмцэж, 2174.1 га талбайд мод, бут, сөөг шинээр тарьж, нөхөн суулгалт хийсэн байна.

Усан сан бүхий газар

Усны сан бүхий газарт нийт 1107.9 га талбайг хамгаалжээ. Ус, усан орчныг цэвэрлэх, цэвэршүүлэх арга хэмжээг 120.3 га талбайд, усны эх булаг, эрэг орчмын газрын хөрсийг цэвэрлэж хамгаалах арга хэмжээ авсан 945.9 га, усны үер, эвдрэлээс хамгаалах арга хэмжээг 41.7 га талбайд тус тус авчээ.

Уурхайн эдэлбэр газар

Геологийн эрэл хайгуул, уул уурхайн ашиглалтын явцад ухагдаж эвдэрсэн 7210.6 га газарт хамгаалалтын арга хэмжээ авснаас нийт 3428.5 га талбайг эргүүлэн дарж булсан, 3781.1 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн байна.

Улсын хэмжээнд Өвөрхангай аймагт 350709.42 га, Дундговь аймагт 92319.09 га, Төв аймагт 631525 га, Хөвсгөл 376044.8 га, Увс аймагт 91869.29 га талбайг тус тус хамгаалах арга хэмжээ авсан нь эхний байруудад орж байна.

Архангай, Баян-Өлгий аймгуудад ухагдаж эвдэрсэн газрыг дарж булах, биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай байхгүй байна.

Газар хамгаалах арга хэмжээний дийлэнх буюу 88,4 хувь нь бэлчээр ба бусад өвслөг ургамалтай газарт байгаа бөгөөд сэлгэн ашиглах, даацыг тохируулах, хортон мэрэгчдийн хөнөөлтэй тэмцэх, ашиглалтаас чөлөөлөх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

2.6. ГАЗРЫН ТӨЛБӨР НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТ /МАЯГТ ГТ-8/

Газрын төлбөрийг Засгийн газрын 1997 оны 152 дугаар тогтоол, 1997 онд батлагдан өнөөг хүртэл мөрдөгдөж буй “Газрын төлбөрийн тухай хууль”-ийн дагуу ногдуулж, төвлөрүүлж байна.


Энэ хугацаанд газрын төлбөрөөс орон нутгийн төсөвт нийт 293 тэрбум 255 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлээд байна.

Хүснэгт 2.6.1: Газрын төлбөрийн гүйцэтгэл

Он	Газрын төлбөрийн төлөвлөгөө / сая.төг/	Гүйцэтгэл / сая.төг/	Гүйцэтгэл /%/
1998	1,919.6	1,524.5	80
1999	2,678.6	1,764.2	66
2000	3,221.5	2,895.0	90
2001	4,673.6	5,401.9	116
2002	5,570.7	6,163.1	110
2003	7,303.4	7,962.0	109
2004	11,840	11,795.2	99
2005	13,867.6	14,045.2	101
2006	14,323.0	15,780.7	110
2007	19,786.8	20,093.7	102
2008	24,790.4	25,543.4	102
2009	28,006.6	29,472.4	105
2010	29,311.7	30,448.6	104
2011	31,280.7	33,556.8	107
2012	39,031.3	43,623.2	112
2013	42,222.2	43,183.1	107
Нийт	269,171.7	293,255.0	109

Улсын хэмжээнд газар эзэмшигч, ашиглагчийн тоо нэмэгдэхийн зэрэгцээ газрын төлбөрөөс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийн хувь жил ирэх бүр өсөж байна. /Хүснэгт 2.6.1/

2013 онд улсын хэмжээнд газрын төлбөрийн орлогоос нийт 43 тэрбум 183.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, газрын төлбөрийн төлөвлөгөөг 114%-аар биелүүлсэн ба өмнөх оны орлоготой харьцуулахад 440.1 сая төгрөгөөр буурсандүнтэй байна /Зураг 2.6.1/.



Зураг 2.6.1: Газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /оноор/

2013 оны газрын төлбөрийн орлогыг аймаг тус бүрээр гаргавал Баянхонгор, Говьсүмбэр, Хэнтий, Баян-Өлгий, Сүхбаатар аймгуудын газрын төлбөр 137-196 хувь, Булган, Дундговь, Төв аймгууд 95-100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Дээр дурдсанаас бусад аймгуудын хувьд газрын төлбөрийн төлөвлөгөөний биелэлт 101-137 хувьтай байна. /Зураг2.6.2/



Зураг 2.6.2: Аймгуудын 2013 оны газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөний биелэлт

Урьд оны үлдэгдэл газрын төлбөрийг төсөвт төвлөрүүлсэн, ашигт малтмалын хайгуулын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан компаниуд ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй болсон, уул уурхайн ашиглалтын болон том хэмжээний үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн тоо өмнөх жилээс нэмэгдсэн зэрэг нь 2013 оны газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл давж биелэхэд нөлөөлсөн байна.

Газрын төлбөрийн орлогыг давуулан биелүүлсэн аймгуудыг авч үзвэл:

Баянхонгор аймгийн Шинэжинст суманд үйл ажиллагаа явуулж буй Гоби Коулд Энд Энержи ХХК-д дэд бүтэц, үйлдвэр барих 1732 га, нүүрс угаах үйлдвэр 93 га, авто замын доорхи газар 1600 га, цахилгаан эрчим хүчний станцын 602 га газрыг шинээр эзэмшүүлж 45239.6 мянган төгрөгийг газрын төлбөрийн орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Мөн Жаргалант, Бууцагаан, Баян-Өндөр, Заг, Өлзийт, Баянговь, сумдуд 2013 онд төлбөрийн төлөвлөгөө 900.0-1000.0 мянган төгрөг төлөвлөгдсөнөөс 1256.4-3289.9 мянган төгрөг давуулан биелүүлсэн байна.

Сүхбаатар аймгийн газрын төлбөрийн төлөвлөгөө давж биелэх болсон шалтгаан нь Мөнххаан, Уулбаян, Эрдэнэцагаан, сумдад ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй уул уурхайн компаниуд үйл ажиллагаа явуулж эхэлсэнтэй холбоотой байна.

Хэнтий аймгийн Баянхутаг, Баянмөнх, Дархан, Дэлгэрхаан, Жаргалтхаан, Батширээт, Баян-Адрага, Дадал, Норовлин, Батноров, Баян-Овоо, Мөрөн, Хэрлэн, Өлзийт, Бэрх, Хэрлэнбаян улаан зэрэг сумууд 33855 сая төгрөг давуулж 100-665 хувиар биелүүлсэн байна. Мөн 2013 онд Мөрөн, Хэрлэн сумдад тариалангийн зориулалтаар 5000 га олгож 1.930.000 төгрөг, Галшар, Дархан, Бор-Өндөр сумдад уурхайгаас 10.000.000 төгрөг төвлөрүүлсэн ба урьд оны газрын төлбөрийн үлдэгдэлийг өвөлжөө хаваржааны доорхи газрын төлбөр оруулсан байна.

Говьсүмбэр аймаг газрын төлбөрийн орлого давуулан биелүүлсэн шалтгаан нь урьд оны газрын төлбөрийн үлдэгдлийг барагдуулан ажилласан ба 2013 онд 137 хувийн өсөттэй ажилласан байна.

Завхан аймгийн хувьд Асгат сумын гурилын үйлдвэрийн газрын төлбөр, Дөрвөлжин сумд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа

Баян-Айраг “эксплорэйшн” ХХК-ны 3 жилийн газрын төлбөр, Тэлмэн сумын дулааны цахилгаан станцын газрын төлбөрүүд тус тус нэмэгдэн орж газрын төлбөрийн төлөвлөгөөг 727 хувиар биелүүлсэн байна.

Сэлэнгэ аймгийн хувьд “Газрын төлбөрийн тухай” хуулинд Улсын хилийн зурвас газарт газар эзэмшиж, ашиглаж буй иргэн аж ахуйн нэгж байгууллагыг газрын төлбөрөөс чөлөөлөхөөр заасны дагуу Сэлэнгэ аймгийн ИТХ тэргүүлэгчдийн тогтоолоор Алтанбулаг, Түшиг сумдыг газрын төлбөрөөс бүрэн чөлөөлсөн боловч хилийн зурвасаас гадна орших эзэмшил, ашиглалтын нэгж талбаруудаас газрын төлбөрийн орлогыг төвлөрүүлсэн байна. Тухайлбал: Алтанбулаг суманд Улсын хилийн зурвасын 5 км-ын радиусаас гадна орших хот, тосгон, бусад суурины барилга, байгууламжийн дэвсгэр газар 53.293 га талбайгаас газрын төлбөрт 6.0 мянган төгрөг, ШТС-ын 0.3 га талбай 2.4 мянган төгрөг, 777.2 га тариалангийн газраас 5156 мянган төгрөг, Түшиг суманд Улсын хилийн зурвасын 5 км-ын радиусаас гадна орших ашигт малтмал /нүүрс/-ын олборлолт явуулдаг “Редхил Монголиа” ХХК-ны ашиглалтын “А” лиценз бүхий 811.53 га талбайгаас 20676.8 мянган төгрөгийг тус тус орон нутгийн төсөвт оруулсан.

Өмнөговь аймаг 2013 оны газрын төлбөрийн төлөвлөгөөг 68071.29 мянган төгрөгөөр дутуу биелсэн байна. Энэ нь Ханбогд сумын ногдуулалтаас Оюутогой ХХК-ний 250844.0 мянган төгрөг, Даланзадгад сумын ногдуулалтаас “Сантранс” ХХК-ийн газар эзэмших эрхийг цуцалсанаас 22870.0 мянга төгрөг төлөөгүй. Мөнтус аймгийн Баян-Овоо, Мандал-Овоо, Хүрмэн, Цогт-Овоо сумуудад үйл ажиллагаа явуулдаг “ЭНК” ХХК, “Олон овоот гоулд” ХХК, “Болд Фо Ар Да” ХХК, “Скайнетворкс” ХХК зэрэг компаниуд нь газрын төлбөрөө дутуу төлсөн ба Ханбогд суманд үйл ажиллагаа явуулдаг Оюутолгой ХХК-ийн зарим ашиглалтын газар нь хүчингүй болсон, зэргээс шалтгаалан газрын төлбөрийн төлөвлөгөө биелээгүй байна.

Булган аймгийн ИТХ-аас 2013 оны газрын төлбөрийн төлөвлөгөөг өндөр хэмжээгээр баталсан нь газрын төлбөрийн төлөвлөгөө тасарахад нөлөөлж байгаа ч тайлангийн хугацаанд газрын төлбөрийн орлогоос төсөвт төвлөрүүлбэл зохих төлбөрийг тайлангийн хугацаанд төсөвт төвлөрүүлсэн орлогод харьцуулахад 98 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 2.6.2: Аймгуудын 2013 оны газрын төлбөрийн төлөвлөгөөний биелэлт

Д/д	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	Газрын төлбөрийн төлөвлөгөө (мян.төг)	Газрын төлбөрийн төлөвлөгөөний гүйцэтгэл (мян.төг)	Биелэлт (%)
1	Архангай	148,048,9	149,241.7	108%
2	Баянхонгор	75,360,0	148,392.8	196%
3	Баян-Өлгий	79,930,0	123,892,6	155%
4	Булган	130,000,2	123,500,0	95%
5	Говь-Алтай	69,144,3	83,916,2	121%
6	Говьсүмбэр	75,000,0	102,892,6	137%
7	Дархан-Уул	500,000,0	581,813,9	116%
8	Дорнод	251,094,0	258,943,7	103%
9	Дорноговь	445,000,0	458,020,1	102%
10	Дундговь	150,000,0	145,810,1	97%
11	Завхан	61,300,0	445,748,8	727%
12	Орхон	10,177,770,0	10,375,932,8	101%
13	Өвөрхангай	100,343,7	106,800,8	106%
14	Өмнөговь	3,335,000,0,	3,266,928,7	98%
15	Сүхбаатар	39,000,0	70,696.2	186%
16	Сэлэнгэ	400,000,0	459,921,3	115%
17	Төв	934,999,5	937,199,9	100%
18	Увс	90,000.0	110,848,9	123%
19	Ховд	96,000,0	122,340.9	127%
20	Хөвсгөл	189,714,2	234,293,5	123%
21	Хэнтий	90,000,0	123,935,3	137%
22	Улаанбаатар	24,784,500,0	24,752,085.6	99,9%
Нийт дүн		42,222,204.81	43,185,108.4	102%

2013 оны газрын төлбөрийн орлогын төлөвлөгөө улсын хэмжээнд 108 %-аар биелэсэн байна.

Хүснэгт 2.6.3: Аймгуудын 2012 оны болон 2013 оны газрын төлбөрийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн зөрүү

Д/д	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	2012 он		2013 он		Тайланг он болон өмнөх оны гүйцэтгэлийн өөрчлөлт (+өссөн- буурсан)
		Газрын төлбөрийн төлөвлөгөө (мян.төг)	Газрын төлбөрийн төлөвлөгөөний гүйцэтгэл (мян.төг)	Газрын төлбөрийн төлөвлөгөө (мян.төг)	Газрын төлбөрийн төлөвлөгөөний гүйцэтгэл (мян.төг)	
1	Архангай	27,228.6	76,420.2	148,048.9	149,241.7	11,928.6
2	Баянхонгор	108,000.0	200,098.2	75,360,0	148,392.8	-51,705.3
3	Баян-Өлгий	85,000.0	115,457.4	79,930,0	123,892.6	43,962.6
4	Булган	129,095.6	151,039.3	130,000,2	123,500.0	88,533.0
5	Говь Алтай	73,947.5	86,282.6	69,144,3	83,916.2	23,663.5
6	Говь сүмбэр	35,000.0	79,694.8	75,000,0	102,892.6	23,197.8
7	Дархан-Уул	420,000.0	453,214.8	500,000,0	581,813.9	128,599.1
8	Дорнод	200,000.3	256,100.0	251,094,0	258,943.7	28,437.0
9	Дорноговь	190,000.0	241,632.9	445,000,0	458,020.1	216,387.2
10	Дундговь	100,000.0	152,937.3	150,000,0	145,810.1	-71,2720
11	Завхан	59,025.0	59,441.0	61,300,0	445,748.8	386,3078
12	Орхон	8,256,500.0	8,340,835.5	10,177,770,	10,375,932.8	198,162.8
13	Өвөрхангай	89,346.1	102,487.3	100,343,7	106,800.8	4,313.5
14	Өмнөговь	3,122,542.6	3,259,907.8	333,5000,0,	3,266,928.7	70,209.1
15	Сүхбаатар	67,000.0	71,374.1	39,000,0	72,647.6	1,273.5
16	Сэлэнгэ	450,000.0	350,259.0	400,000,0	459,921.3	109,662.39
17	Төв	784,443.8	972,952.0	934,999,5	937,199.9	-35,752.4
18	Увс	90,000.0	101,656.0	90,000.0	110,848.9	91,929.2
19	Ховд	80,000.0	81,919.9	96,000,0	116,000.0	34,080.1
20	Хөвсгөл	199,962.3	223,178.6	189,714,2	234,293.5	11,114.9
21	Хэнтий	100,000.00	109,489.50	90,000,0	123,935.3	14,445.8
22	Улаанбаатар	24,364,200.0	28,136,869.1	24,784,500,0	24,752,085.0	-3,384,784.10
23	Нийт дүн	39,031,291.8	43,623,247.2	42,222,204,809	43,183,157.0	-4381387

Аймаг, нийслэлийн ГХБХБГ, Газрын албанаас газрын төлбөрөө төлөөгүй газар эзэмшигчдийн төлбөрийг барагдуулах талаар хууль, хяналтын байгууллагатай хамтран ажиллах, холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авах, газрын төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн бие даасан орон тоогоор ажиллан сум, дүүргийн газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтөд хяналт тавьж байгаатай холбоотойгоор газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл өмнөх жилүүдээсээ өссөн дүнтэй байна.

Нийслэлийн хэмжээнд 2013 онд газрын төлбөрийн орлогод 49205.7 сая төгрөгийг төвлөрүүлж


төлөвлөгөөг 109.9 хувиар биелүүлсэн байна. Үүнээс 24752.1 сая төгрөг нь газрын төлбөр, 24453.6 сая төгрөг нь дуудлага худалдааны анхны үнийг газрын төлбөрийн орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

2013 оны газрын төлбөрийн орлогыг Газрын нэгдмэл сангийн ангилалын төрлөөр нь авч үзвэл хот тосгон бусад суурин газрын төлбөр 70.6 хувь, хөдөө аж ахуйн газраас 3.2 хувь, ойн сан бүхий газраас 2 хувь, усан сан бүхий газраас 1 хувь, тусгай хэрэгцээний газраас 22.8 хувь аялал жуулчлалын газраас 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 2.6.4: Газрын төлбөрийн орлого /Газрын нэгдмэл сангийн ангиллаар/

Д/д	Газрын нэгдмэл сангийн ангиллын төрөл	Газрын төлбөрийн орлого /мян.төг/				
		2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он
	Хөдөө аж ахуйн газар	930,025.4	1,258,935.1	1,369,127.6	1,102,81.6	1,711,700.6
1	Бэлчээр	714,33.9	907,02.7	702,26.4	745,86.8	106,048.7
2	Хадлан	20140.8	386,55.2	402,40.4	28,849.2	31,240.4
3	Тариалан	478,920	836,736.2	100,01.7	681,442.8	873,389.2
4	ХАА-н барилга, байгууламжийн дэвсгэр газар	359,530.5	292,841	258,485.5	317,935.8	701,022.1
	Хот, тосгон бусад суурины газар	23,046,302.5	26,396,637.7	28,232,119.6	36,540,378.6	41,459,571.2
5	Барилга, байгууламжийн дэвсгэр газар	15,652,579.5	15,888,447	15,471,147.5	23,354,529.0	19,005,690.0
6	ШТС, авто машины зогсоол		505,435.6	989,536.5	813,527.4	698,577.4
7	Гэр хороолол	464,729.4	220,095.1	250,753.6	269,961.5	430,311.8
8	Уул уурхай	102,793,28.7	990,1052	11,520,759.0	12,102,360.5	14,788,651.8
9	Ойн сан бүхий газар	24,6392	362,605.3	443,781.0	537,134.4	509,866.9
10	Усны сан бүхий газар	17,293.3	19,816.1	16,853.2	87,925.6	13,751.6
11	Тусгай хэрэгцээний газар		2,290,859.0	3,117,336.7	4,993,664.3	5,657,923.9
12	Аялал жуулчлалын зориулалтаар ашиглаж бай газар		192,821.1	342,840.6	435,987.0	353,476.8
13	Зам шугам сүлжээний газар	916.7	1,358.4	3,4730.9	4,475.6	1,320.5
14	Улсын дүн	29,472,378.8	30,448,604.2	33,556,866.6	43,623,247.1	43,183,157.0

2013 онд газрын төлбөрөөс орон нутгийн төсөвт оруулсан орлогыг газрын нэгдмэл сангийн ангиллаар авч үзвэл хамгийн их хувийг хот, тосгон бусад суурины газар болон уул уурхайн газрын төлбөр, хамгийн бага хувийг усны сан бүхий газар, зам шугам сүлжээний газрын төлбөр эзэлж байна. Энэ нь хот суурин газарт газар эзэмшигч, ашиглагч бусад ангиллын газар эзэмшигч, ашиглагчаас харьцангуй ихээр төвлөрсөнийг харуулж байна.



Зураг 2.6.4: Газрын төлбөрийн орлогын хувь /ГНС-ийн ангиллаар/


2.7. ГАЗАР ӨМЧЛӨЛИЙН ТАЙЛАН /МАЯГТ ГТ-9/

“Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” хууль хэрэгжиж эхэлснээс хойш буюу 2003 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2013 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт 371978 иргэн 40419.9 га газрыг өмчилж авсан байна. Үүнээс:


- 371295 иргэн 40340.8 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнэгүй;
- 403 иргэн 3,7 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнээр нь;
- 280 иргэн 75,31 га газрыг аж ахуйн зориулалтаар давуу эрхээр болон дуудлага худалдаагаар үнээр нь худалдан авч өмчилсөн байна.

Нийт газар өмчилж авсан иргэдийн тоог тухайн нутаг дэвсгэрийн хүн амын тоотой харьцуулбал:

- Аймгийн хэмжээнд 16,78 хувь
- Нийслэлийн хэмжээнд 8,12 хувь
- Улсын хэмжээнд нийт иргэдийн 12,96 хувь нь газраа өмчилж авсан байна




Зураг 2.7.1: Улсын хэмжээнд газар өмчилж авсан иргэдийн тоог нийт хүн амын тоотой харьцуулсан байдал



Зураг 2.7.2: Газар өмчилж авсан иргэдийн тоо /аймгаар/

2013 онд улсын хэмжээнд нийтдээ 42338 иргэн 4008,77 га газрыг өмчилж авсан байна /Зураг 2.7.3/.




Зураг 2.7.3: Улсын хэмжээнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчилж авсан байдал

2013 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр 141 иргэн 14,06 га газрыг аж ахуйн зориулалтаар давуу эрхээр, 56 иргэн 3,25 га газрыг аж ахуйн зориулалтаар дуудлага худалдаагаар, 83 иргэн 58,04 га газрыг газар тариалан /үр тариа, төмс хүнсний ногоо тариалах/-гийн зориулалтаар давуу эрхээр худалдан авч өмчилсөн байна /Зураг 4/. Мөн 403 иргэн 3.7 га газрыг хуульд заасан хэмжээнээс

илүү гарсан газраа худалдан авч өмчилсөн байна.

Үүнээс 2013 онд 18 иргэн 3,08 га газрыг аж ахуйн зориулалтаар давуу эрхээр, 1 иргэн 1,61 га газрыг аж ахуйн зориулалтаар дуудлага худалдаагаар, 5 иргэн 12,03 га газрыг газар тариалангийн зориулалтаар давуу эрхээр худалдан авч өмчилсөн байна /Зураг 2.7.4/.



Зураг 2.7.4: Аж ахуйн зориулалтаар газар өмчилж авсан иргэдийн тоо

3

ДҮГНЭЛТ

2013 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын газрын нэгдмэл санд хөдөө аж ахуйн газар 115361.3 мянган га буюу 73.76 хувь, хот, тосгон бусад суурины газар 699.5 мянган га буюу 0.45 хувь, зам, шугам сүлжээний газар 437.3 мянган га буюу 0.28 хувь, ойн сан бүхий газар 14295.4 мянган га буюу 9.14 хувь, усны сан бүхий газар 686.6 мянган га буюу 0.44 хувь, улсын тусгай хэрэгцээний газар 24931.1 мянган га буюу 15.94 хувийг тус тус эзэлж байна.

Улсын тусгай хэрэгцээний газрын ангилалд улсын тусгай хамгаалалттай газар 20948.3 мянган га буюу 84.0 хувийг, улсын хилийн зурвас газар 3112,0 мянган га буюу 13.0 хувийг, улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар 124,1 мянган га буюу 1.0 хувийг, гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар 0,027 мянган га буюу 0.001 хувийг, шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай 22.9 мянган га буюу 0.009 хувийг, аймаг дундын отрын бэлчээр 586.2 мянган га буюу 2.0 хувийг, улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай 110.9 мянган га буюу 0.4 хувийг, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай 24,5 мянган га буюу 0.1 хувийг, чөлөөт бүсийн газар 2,1 мянган га буюу 0.008 хувийг тус тус эзэлж байна.

Улсын Их Хурлын 2013 оны 52 дугаар тогтоолоор Бүгд Найрамдах Солонгос Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Бүгд Найрамдах Турк Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамдын одоо ашиглаж буй 1.18 га газрыг тус улсын тусгай хэрэгцээнд авсаны дагуу өөрчлөлтийг ГТ-4 тайланд тусгав.

Засгийн газрын 2013 оны 343 тоот тогтоолоор Цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбайн зориулалттай газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан ба эдгээр газрууд нь ГТ-4 тайланд 2003 оноос

хойш тусгагдсан байсан тул 2013 оны ГТ-4 тайланд өөрчлөлт ороогүй болно.

2013 онд улсын хэмжээнд нийт 5536369.4 га газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгоод байна. Үүнд 371702 иргэн гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 40354.73 га газар, 276 иргэн аж ахуйн зориулалтаар 64.28 га газрыг тус тус өмчилж авсан бол 319820 иргэн 303852.16 га, 8432 төрийн байгууллага 3561570.23 га, 19908 аж ахуйн нэгж 1439375.45 га газрыг тус тус эзэмшиж, 57 гадаадын иргэн, харъяалалгүй хүн 17.65 га, 563 гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээд 175562.21 га газрыг тус тус ашиглаж байна. Мөн бусдын эзэмшил 15572.71 га газрыг гэрээний дагуу нийт 912 иргэн, төрийн байгууллага, аж ахуйн нэгж ашиглаж байна.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл зонхилсон, хуурай бүс нутагт оршдог манай оронд уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн талхлагдал, тариалангийн хөрсний үржил шимийн бууралт, ойн түймэр, хортон шавьж, модны замбараагүй хэрэглээ, уул уурхайн зохисгүй үйл ажиллагаанаас үүдэлтэй газрын доройтол, цөлжилт ихээхэн явагдаж байна. Энэхүү доройтлыг “газарт учруулсан хохирол” гэсэн томъёололд хамааруулан хохирлын хэмжээг дэлгэрэнгүй үзүүлэлтүүдээр хүлээн авч, улсын хэмжээнд нэгтгэн дүгнэв.

